

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ, ТЭМДЭГЛЭЛЭЭР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН  
ШИЙДВЭРИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/*

2020.07.22

Улаанбаатар хот

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, танилцуулгыг Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр гаргасан болно. Мөн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийг тус шинжилгээний дүнд үндэслэн хяналтаас хасахаар хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ТАЛААР**

**2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт**

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		<b>Хууль</b> /давхардсан тоогоор/	<b>Хэсэг, заалт</b>
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газраас ирүүлсэн	99	427
	<b>Үүнээс:</b>		
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1
3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 99 хуулийн 427 заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй байна.

## **2.2. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хуулийн хэрэгжилт**

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 21 хуулийн 107 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 21 хуулийн 106 хэсэг, заалт буюу 99.1 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 1 хуулийн 1 хэсэг буюу 0.9 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 21 хуулийн 106 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 17 хуулийн 80 хэсэг, заалт буюу 75.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 хуулийн 6 хэсэг, заалт буюу 5.7 хувь нь хэрэгжих шатанд, 5 хуулийн 13 хэсэг, заалт буюу 12.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 3 хуулийн 3 хэсэг, заалт буюу 2.8 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 4 хэсэг, заалт буюу 3.8 хувь нь үнэлэх боломжгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо		Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	21		107	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	21		106	99.1
<b>Үүнээс:</b>				
- бүрэн хэрэгжсэн	17		80	75.5
- хэрэгжих шатанд	3		6	5.7
- хэрэгжилт хангалтгүй	5		13	12.2
- хэрэгжээгүй	3		3	2.8
- үнэлэх боломжгүй	4		4	3.8

## **ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

### **3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт**

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг давтан ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн <b>Үүнээс:</b>	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг давтан ирүүлсэн	24	53
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

### 3.2. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 7 тогтоолын 53 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын 6 тогтоолын 38 заалт буюу 71.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 4 тогтоолын 15 заалт буюу 28.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 6 тогтоолын 38 заалтаас 5 тогтоолын 24 заалт буюу 63.1 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 тогтоолын 12 заалт буюу 31.6 хувь нь хэрэгжих шатанд, 2 тогтоолын 2 заалт буюу 5.3 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	7	53	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	6	38	71.7
<b>Үүнээс:</b>			
- Бүрэн хэрэгжсэн	5	24	63.1
- Хэрэгжих шатанд	2	12	31.6
- Хэрэгжилт хангалтгүй	2	2	5.3
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	-	-	-

### 3.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй УИХ-ын дараах 4 тогтоолын 15 заалт байна.

	Тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй заалт
1.	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.02.10 №23/	3 дахь заалт;
2.	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” /2017.04.13 №26/	2 дахь заалт;
3.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2019.06.06 №62/	1г/, 1д/, 1е/; 2л/; 3а/, 3г/, 3е/; 5б/; 6а/, 6б/; 7б/; 2 дахь заалт.
4.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2019.12.12 №102/	1 дэх заалт.

## ДӨРӨВ. БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

### 4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлж, давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн <b>Үүнээс:</b>	82	420
	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй байна.

### 4.2. Хууль зүйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Хууль зүйн байнгын хорооны 6 тогтоолын 62 заалт мэдээллийн сангийн хяналтад байгаагаас 2019 оны жилийн эцсийн байдлаар 6 тогтоолын 52 заалт буюу 83.9 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 3 тогтоолын 10 заалт буюу 16.1 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ХЗБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	6	62	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	6	52	83.9
<b>Үүнээс:</b>			
- Бүрэн хэрэгжсэн	6	36	69.2
- Хэрэгжих шатанд	3	6	11.5
- Хэрэгжилт хангалтгүй	3	3	5.8
- Хэрэгжээгүй	2	7	13.5
- Үнэлэх боломжгүй	-	-	-

#### 4.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй дараах 3 тогтоолын 10 заалт байна.

Тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй заалт
1. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2015.10.01 №28/	4 дэх заалт;
2. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2016.11.16 №10/	3.4 дэх заалт;
3. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2018.01.31 №02/	2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4; 3.6, 3.8, 3.13, 3.20 дахь заалт.

#### ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасах санал ирүүлсэн Монгол Улсын 17 хуулийн 80 хэсэг, заалт, УИХ-ын 5 тогтоолын 25 заалт, Байнгын хорооны 6 тогтоолын 36 заалтыг тус тус хавсралтаар хүргүүлэв.

#### ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах нийт хууль тогтоомжийн хэрэгжилтийг дунджаар 84.9 хувьтай ирүүлсэн байх ба үүнээс бүрэн хэрэгжсэн заалтын дундаж 70.2 хувь байна.

2/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хугацаа хоцруулж ирүүлдэг дутагдал давтагдаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,  
ХЯНАЛТААС ХАСАХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1.	<b>Хууль тогтоомжийн тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2015.05.29	<p>15.3. Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.</p> <p>15.4. Хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.</p> <p>15.7. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах нийгмийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг дангаар батална: 15.7.1. Төрийн байгуулалт, эрүү, иргэний зэрэг салбарын бус нийтлэг харилцаа; 15.7.2. Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар хуульд тусгайлан зааснаас бусад асуудал.</p> <p>30.3. Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хуулийн төслийн үзэл баримтлал тухай бүр баталж байгаа бөгөөд 2020 онд 12 хуулийн төслийн үзэл баримтлалыг баталсан.</p> <p>Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч, хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хуулийн төслийн үзэл баримтлал тухай бүр баталж байгаа бөгөөд 2020 онд 2 хуулийн төслийн үзэл баримтлал баталсан.</p> <p>Төрийн байгуулалт, эрүү, иргэний зэрэг салбарын бус нийтлэг харилцаа болон Засгийн газрын хууль зүй, дотоод хэргийн эрхлэх асуудлын хүрээ хариуцсан гишүүнд хамаарахаар хуульд тусгайлан зааснаас бусад асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухай бүр дангаар баталдаг бөгөөд хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг баталж байна.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А 07, А 09 тоот тушаалаар хамтран баталсан.</p>
2.	<b>Захиргааны ерөнхий хууль</b> 2015.06.19	72.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүйн сайдын 2016 оны 07-р сарын 01-ний өдрийн “Журам батлах тухай” А/226 дугаарын тушаалын хавсралтаар “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам” батлагдсан. Тус хэлтэс үйл ажиллагаандаа уг журмыг дагаж мөрдөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.	<b>Галын аюулгүй байдлын тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2015.07.02	5.2. Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон гал түймрийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.	“Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийг Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор, “Гал түймрийн улсын хяналтын дүрэм”-ийг Засгийн газрын 2018 оны 40 дугаар тогтоолоор тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
		10.4. Гал түймэртэй тэмцэх гэрээт анги, гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаалаар доорхи журмуудыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. - Гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журам, - Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам, - Гал түймэртэй тэмцэх гэрээт анги, гал түймрийн улсын хяналтын байцаагч ажиллуулах журам.
		14.3. Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажилтанд тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.	“Гамшгаас хамгаалах сайн дурны хэсгийн зардал урамшуулал олгох журам”-ыг Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар батлуулав.
		22.2. Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах журмыг Засгийн газар батална.	“Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах журам”-ыг Засгийн газрын 2018 оны 357 дугаар тогтоолоор батлуулсан.
4.	<b>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай</b> /шинэчилсэн найруулга/ 2015.07.08	18.4. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаар тушаалаар “Тээврийн хэрэгслийн жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”-ыг баталсан.
5.	<b>Цагдаагийн албаны тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2017.02.09	6.2. Цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 76 дугаар тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын тоог тогтоож, мөн газрын зохион байгуулалтын бүтцийг баталсан.
		6.7. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл, бусад онцлогийг харгалзан цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны болон автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг тухайн хуульд нийцэж байгаа тул шинэчлэх шаардлагагүй гэж үзэн мөрдөж байгаа болно.
		8.2. Цагдаагийн албаны бэлгэ тэмдэг, тугны загвар болон туг, бэлгэ тэмдгийг хэрэглэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн албаны бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам батлах тухай” 73 дугаар тогтоолоор “Цагдаагийн албаны бэлгэ тэмдгийн загвар”, “Цагдаагийн албаны тугны загвар”, “Цагдаагийн албаны туг хэрэглэх журам”, “Цагдаагийн албаны бэлгэ тэмдэг хэрэглэх журам”-ыг тус тус баталсан.
		9.2. Цагдаагийн алба хаагчийн тангараг анх болон давтан өргөх ёслолын журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 75 дугаар тогтоолоор “Цагдаагийн алба хаагчийн тангараг анх болон давтан өргөх ёслолын журам”-ыг баталсан.

	12.2. Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт батлах тухай” 281 дүгээр тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалтыг хавсралтаар баталсан. Тайлбар: Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2018 оны 142, 368 дугаар, 2019 оны 444 дүгээр, 2020 оны 2 дугаар тогтоолоор нэмэлт тус тус орсон.
	16.2. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална.	Засгийн газрын 2020 оны “Хөтөлбөр батлах тухай” 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан.
	26.6. Түр саатуулах байрны дэглэм, журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн “Түр саатуулах байрны дэглэм, журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/85 дугаар тушаалаар баталсан.
	47.3. Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”-ыг баталсан.
	47.4. Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 2017 оны А/224, А/102 дугаар тушаалаар “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ыг баталсан.
	58.9. Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 2017 оны А/97, А/42 дугаар тушаалаар “Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журам”-ыг баталсан.
	61.6. Энэ хуулийн 61.1.19-д зааснаас бусад мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /61.1.19-д цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэлээс бусад мэдээлэлд хамаарах “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-ыг баталсан.
	62.11. Иргэний зөвлөлийн дүрмийг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 дугаар тушаалаар “Иргэний зөвлөлийн дүрэм”-ийг баталсан.
	75.3. Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад цагдаагийн цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журмыг Засгийн газар батална. /75.2.Цагдаагийн дээд цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална./	Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 72 дугаар тогтоолоор “Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-ыг баталсан.
	77.6. Цагдаагийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/146 дугаар тушаалаар “Цагдаагийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг баталсан.



	<p>86.12. Энэ зүйлд заасан нөхөх олговор, мөнгөн тусламж олгох журам, энэ хуулийн 86.9-д заасан үнэ төлбөргүй эмчилгээ хийх эмнэлгийн жагсаалт, энэ хуулийн 86.10-т заасан зардал олгох журам, энэ хуулийн 86.11-т заасан сэтгэлзүйн нөхөн сэргээх эмчилгээ хийх журмыг тус тус Засгийн газар батална.</p> <p><i>/86.9-д Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ.</i></p> <p><i>86.10-т Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, эдгээр үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.</i></p> <p><i>86.11-т Гэмт хэрэгтэй тэмцэх, дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна./</i></p>	<p>Засгийн газрын 2017 оны “Журам, жагсаалт батлах тухай” 249 дүгээр тогтоолоор “Цагдаагийн алба хаагчид нөхөх олговор, мөнгөн тусламж олгох журам”, “Цагдаагийн алба хаагчид замын зардал олгох журам”, “Цагдаагийн алба хаагчийг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”, “Цагдаагийн алба хаагчид үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын жагсаалт”-ыг тус тус баталсан.</p>
	<p>88.3. Цагдаагийн дээд цолтой алба хаагчийн дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, цагдаагийн бусад алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журмыг Засгийн газар, дүрэмт болон ажлын хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга тус тус батална.</p>	<p>Цагдаагийн албан тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх хэсгийг 2020.01.10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцож, цагдаагийн дээд цолгүй болсон.</p> <p>Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журам батлах тухай” 155 дугаар тогтоолоор “Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны загварын товчоо”, “Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа”, “Цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журам”-ыг тус тус, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/143 дугаар тушаалаар “Дүрэмт болон ажлын хувцас хэрэглэх журам”-ыг баталсан.</p>
	<p>89.2. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.</p>	<p>Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшил олгох журам батлах тухай” 74 дүгээр тогтоолоор “Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшил олгох журам” баталсан.</p>
	<p>91.5. Энэ хуулийн 91.2-т заасан хугацаа сунгах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/147 дугаар тушаалаар “Цагдаагийн алба хаагчийн алба хаах хугацаа сунгах журам”-ыг баталсан.</p>

		<i>/91.2-т Энэ хуулийн 91.1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн цагдаагийн алба хаагчийн алба хаах хугацааг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж болно./</i>	
		92.2. Цагдаагийн байгууллагын шагналын төрлийг цагдаагийн төв байгууллагын даргын саналыг үндэслэн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	Цагдаагийн ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/99 дүгээр тушаалаар цагдаагийн байгууллагын шагналын төрлийг тогтоосон.
6.	<b>Дотоодын цэргийн тухай</b> 2017.02.09	5.1.2. 5.1.Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмийг батлах;	Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийг баталсан.
		5.1.3. дотоодын цэргийн алба хаагчид олгох албаны нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу тогтоох;	Засгийн газрын 2017 оны 285 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ тогтоох, нэмэгдэл олгох журам”-ыг баталсан. Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам /хөдөлмөрийн дотоод журам”-д дотоодын цэргийн албан тушаалын цалингийн зэрэглэлийн шатлал тооцох хугацаа, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл тооцож олгох хугацаа, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох албан тушаал, цэргийн цолны нэмэгдлийн хувь хэмжээг тусгаж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/02 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.
		5.1.4. улсын онц чухал объектын жагсаалтыг батлах;	Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-ыг баталсан.
		5.1.5. дотоодын цэргийн жинхэнэ алба хаах хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчийн тоо, нийт бие бүрэлдэхүүний орон тооны дээд хязгаарыг тогтоох;	Засгийн газрын 2017 оны мн/282 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн нийт бие бүрэлдэхүүний орон тооны дээд хязгаар”-ыг баталсан.
		6.1.2. 6.1.Дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: дотоодын цэрэг энэ хуулийн 11.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийн төрөл, тэдгээрийг хэрэглэх зааврыг дотоодын цэргийн командлагчийн саналыг үндэслэн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах;	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаалаар “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”-ыг баталсан.
		6.1.3. дотоодын цэргийн командлагчийн саналыг үндэслэн дотоодын цэргийн анги байгуулах, байршлыг өөрчлөх, татан буулгах саналыг Засгийн газарт—танилцуулж, шийдвэрлүүлэх;	Засгийн газрын 2017 оны 280 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн 2 анги байгуулах тухай” шийдвэрийг баталж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын мөн оны н/90 дугаар тушаалаар өмнө хэрэглэж байсан “Цэргийн ангийн захидал харилцааны дугаар”-ыг сэргээн олгосон.
		10.2. Дотоодын цэргийн бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/217 дугаар тушаалаар “Дотоодын цэргийн бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам”-ыг баталж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн

			2017 оны А/204 дүгээр тушаалаар 05 дугаар ангид “Байлдааны туг, одон, хүндэт нэр”-ийг, мөн командлагчийн 2017 оны А/205 дугаар тушаалаар 805 дугаар ангид “Байлдааны туг”-ийг тус тус шилжүүлэн олгосон.
		18.2. Дотоодын цэргийн алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт, бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/89 дүгээр тушаалаар “Дотоодын цэргийн алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт, бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам”-ыг баталсан.
		18.3. Дотоодын цэргийн алба хаагч энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/88 дугаар тушаалаар “Дотоодын цэргийн алба хаагч энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”-ыг баталсан.
		28.3. Энэ хуулийн 28.2-т заасан галт зэвсэг хэрэглэх зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална. <i>/28.2-т Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно./</i>	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2018 оны А/64, А/41 дүгээр хамтарсан тушаалаар “Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэх заавар”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны өдрийн А/57 дугаар тушаалаар “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”-ыг тус тус баталсан.
		33.2. Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хүнийг 6 цаг хүртэлх хугацаанд түр саатуулж болох бөгөөд хүнийг түр саатуулах зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2018 оны А/75, А/46 дүгээр хамтарсан тушаалаар Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хүнийг түр саатуулах заавар”-ыг батлуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.
7.	<b>Зөрчил шалган шийдвэрлэх тухай</b> 2017.05.18	1.11.3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааны зардлыг тооцох журмыг Засгийн газар батална. <i>/1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд дараахь зардал хамаарна: 1.1.хохирогч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид төлөх зардал; 1.2.эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, устгахад гарах зардал; 1.3.тухайн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал; 1.4.хохирол, хор уршгийн үнэлгээ, шинжилгээ хийлгэхтэй холбоотой зардал/</i>	Засгийн газрын 2017 оны 196 дугаар тогтоолоор Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох журам”-ыг баталсан.
		4.10.4. Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горимыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор “Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горим”-ыг баталсан.

		5.1.4. Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.	Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2017 оны А/70, А/174 дүгээр хамтарсан тушаалаар “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”-ыг баталсан.
		5.2.7. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1.2, 1.3, 1.4 дэх заалтад заасан саатуулах байрны дэглэм, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/5.1.2.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар;</i> 5.1.3.хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор 7 хүртэл хоногийн хугацаагаар; 5.1.4.гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол эрүүгийн хэргийн шүүх тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг 14 хүртэл хоногийн хугацаагаар/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 05-ний өдрийн А/185 дугаар тушаалаар “Саатуулах байрны дэглэм, журам”-ыг баталсан.
		7.2.7. Шийтгэлийн хуудасны маягтыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны “Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай” 194 дүгээр тогтоолоор баталсан.
		7.5.11. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ыг баталсан.
8.	<b>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2017.06.09	149.2. Зөрчил үйлдэхэд ашигласан хураагдсан эд зүйл, хэрэгсэл, зөрчил үйлдэж олсон хураагдсан хөрөнгө, орлогыг худалдан борлуулах, шилжүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-д Засгийн газрын 2019 оны 157 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.
		157.2. Энэ хуулийн 157.1-д заасан өвчний жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. <i>/157.1-д Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн нь тогтоогдсон бол ажлын 3 өдрийн дотор ялтныг ялаас чөлөөлүүлэх, ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналаа ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор дүгнэлт үйлдэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ./</i>	“ХЗДХС, ЭМС-ын 2019.07.26-ны өдрийн А/152, А/366 дугаар хамтарсан тушаалаар “Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, “Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”-ыг баталсан.

		<p>255.1. Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, хорих ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>“ХЗДХС, ЭМС-ын 2019.07.26-ны өдрийн А/152, А/366 дугаар хамтарсан тушаалаар “Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, “хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”-ыг баталсан.</p>
		<p>267.4. Хорих ангийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хамтарсан үйлдвэрлэлээс олсон орлогыг хорих ангийн аюулгүй байдал, хоригдлын ахуйн нөхцөлийг сайжруулах, хоригдлыг нийгэмшүүлэхэд зарцуулах бөгөөд хөрөнгийг хуваарилах, түүнд хяналт тавих журмыг санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>ХЗДХС, Сангийн сайдын 2019.03.21-ний өдрийн А/40, 67 дугаар хамтарсан тушаалаар “Хорих ангийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хамтарсан үйлдвэрлэлээс олсон орлогыг хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан.</p>
		<p>269.2. Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, газар зүйн байршил, дэд бүтэц, ял шийтгүүлсэн хүний болон гүйцэтгэх баримт бичгийн тоог харгалзан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, орон тооны болон автомашин, техник, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг Засгийн газар батална.</p>	<p>Улсын Их Хурлын 2020.01.10-ны өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 6 дугаар зүйлд “269.2 дахь заалтыг хүчингүй” болгосон.</p>
		<p>269.4. Энэ хуулийн 269.3-т заасан зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журмыг Засгийн газар батална. <i>/269.3-т Энэ хуулийн 11.3-т заасан хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуульд заасан тохиолдолд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдээр нөхөн төлүүлнэ./</i></p>	<p>Улсын Их Хурлын 2019.02.02-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд “Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ” гэж өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус журмын төслийг боловсруулж, батлуулах хугацааг хойшлуулсан болно.</p>
<p>9.</p>	<p><b>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2016.12.22</p>	<p>11.1.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг энэ хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу зохион байгуулах;</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс он дуустал “Хайр өвтгөдөггүй” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сан зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран улсын хэмжээнд зохион байгуулж байна. Арга хэмжээний хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 4.5 хувиар буурсан бол зөрчил 68.1, баривчлагдсан хүн 50.3 хувиар тус тус өссөн.</p>

		<p>11.1.2. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон хүчирхийлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;</p>	<p>Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн хор уршиг, хууль тогтоомжийг сурталчилсан зорилтот 6, урлаг, соёл, спортын олны танил хүнийг оролцуулан нийт 20 видео шторк, сэрэмжлүүлэх зурган постер 51, зорилтот мэдээ 35, нийт 112 мэдээ, мэдээлэл, контентыг шинээр бүтээж, нийтийн цахим сүлжээгээр түгээснийг 3.726.675 хүн үзэж, 136.159 хүн бусадтай хуваалцаж, 17.231 хүнд таалагдсан байна. Мөн гэр бүлийн тэгш харилцаа, зөв хандлагын зөвлөмж, уриалга бүхий 4 төрлийн 22.500 ширхэг А4 хэмжээтэй стикер, 4 төрлийн 13.000 ширхэг тараах материал, 4 төрлийн 600 ширхэг стикер тус тус хэвлүүлж, Улаанбаатар хотын төв замын 4 чиглэлийн сурталчилгааны самбар, орон нутгийн авто зам дагуу байрлах 8 самбар, “JCDecaux” ХХК-ий автобусны буудлын 21 лед дэлгэц, “ССТS” ХХК-ийн зам дагуух 80 лед самбар, нийт 101 лед самбар, олон нийтийн газар, орон сууцны самбар, цахилгаан шатны дотор тал, нийтийн тээврийн автобуса дотор байршуулсан. Гудамж талбай, олон нийтийн газарт байрлах LED дэлгэц, сурталчилгааны 108 самбарт видео мэдээлэл, “Сансар”, “Дидиш”, “Скай медиа” телевизид арга хэмжээний баннер, Нийслэлийн орон сууцны 900 лифтны лед дэлгэц, 700 лифтны мэдээллийн самбарт арга хэмжээний мэдээлэл байршуулж сурталчилсан.</p>
		<p>11.1.3. салбарын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно” гэж заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын үр дүнг сайжруулж, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулсан. Уг хэлтэс нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p>
		<p>11.1.4. гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн нэгдсэн сан” үүсгэн 2018 оны 04 дүгээр сараас ажиллуулж байна. Уг сан нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл, өргөдөл, гомдол, зөрчил, гэмт хэргийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн</p>

		<p>тусламж үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгч этгээдэд авсан арга хэмжээний талаархи мэдээллийг нэгтгэсэн, Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн гишүүд, хүүхэд бүртгэгдсэн талаархи мэдээллийг агуулсан дахин ашиглах боломжтой цахим мэдээллийн бааз юм.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/25 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”, “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ыг тус тус Улсын ерөнхий прокурортой зөвшилцөж баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	11.1.5. хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандартад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх агуулгыг тусгах;	Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа” сэдэвт 2 багц цагийн хичээлийг сонгон судлахаар тусгасан.
	11.1.6. харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;	Цагдаагийн байгууллагын бүх алба хаагчийн албан тушаалын тодорхойлолтод хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг оруулсан. Тухайлбал: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр эргүүлийн офицер, цагдаа гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл очиж шалгах, зөрчил шалгах эрх бүхий алба хаагч зөрчил шалгах, мөрдөгч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг шалгах, сум хорооны цагдаагийн алба хаагч хамтарсан багт ажиллах зэрэг.
	15.1.2. хохирогчид энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий эмнэлэгт ажиллах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг улсын хэмжээнд 11 цэгээр буюу ГССҮТ, СБДЭМТ, ХУД-ын ЗДТГ, Шүүхийн шинжилгээний үндэсний төв, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Хэнтий аймгуудад үзүүлж үйл ажиллагаа нь тогмолжсон. Тус нэг цэгийн үйлчилгээгээр эмнэлгийн тусламж үйлчилгээ, хууль эрх зүй, нийгмийн болон халамжийн, аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.
	15.1.4. гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтыг зохион байгуулах;	ХЗДХЯ, Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад Эрүүл мэндийн салбарын төлөөлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй багаараа хамрагдаж гэр хүчирхийлэлийн эсрэг бүсийн сургагч багш нар бэлтгэх сургалтад бүсчлэн хуваагдаж сургалтыг явуулсан. Улаанбаатар хотын 9 дүүрэг, хөдөөгийн 21 аймгийн нийт 1200 гаруй Эрүүл мэндийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар хүүхэд, өсвөр үеийнхний дунд тохиолддог сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, зөвлөгөө

		өгөх чадварт чиглэгдсэн сургалтыг зохион байгуулж байна. Эрүүл мэндийн хичээлийн 6 агуулгын дагуу багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулж, хянаж байна.
	16.1.1. хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;	Архангай аймгийн Хөгжимт драмын театр Хүний эрхийн хороо, Цагдаагийн газартай хамтран төсөл хэлбэрээр 2017 онд “Хүсэл” драмын жүжиг, 2019 онд “Бариа” драмын жүжиг тус тус тавьж, аймгийнхаа бүх зорилтот бүлэг, сургуулийн бүлэг, сургуулийн ахлах ангийн сурагчдад үнэ төлбөргүй үзүүлсэн. Баянхонгор аймгийн Тэмүжин театр “Хайр түгээе” аяны хүрээнд “Сүүдрээс гэрэлтэх хайр”, “Гарын таван хуруу” жүжгийг 10 сум, аймгийн төвд 16 удаа тоглож, 6009 үзэгчдэд толилуулсан. Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь 2018 онд Ч.Лодойдамбын зохиол “Гарын таван хуруу” жүжгийг найруулагч СТА С.Баярсайханы найруулгаар тайзны бүтээл болгон туурвиж нийт 23 удаагийн тоглолтоор 600 гаруй үзэгчдэд толилуулсан. Ховд аймгийн Хөгжимт жүжгийн театр 2017 оны 12 дугаар сард Д.Жүгдэрбарамын зохиол “Заавал эдлэх хайр” драмын жүжгийг тайзнаа тавьсан. Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын уран бүтээлчид 2019 онд “Эрүүл зан үйл архидалтгүй Өлгий” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд богино хэмжээний ТВ зохиомж 4-ийг хийж сурталчлан аймагтаа 2 дугаар байранд орсон. 2017 онд Дэлхийн зөн олон улсын байгууллага аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтарч гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, компьютер тоглоомд донтох сэдвийн хүрээнд 12 сум, аймгийн төвд 4 хошин тоглолт хийж 4600 үзэгчдэд үйлчилсэн.
	17.2. Улсын ерөнхий прокурор хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна.	Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/22, А/31 дүгээр хамтарсан тушаалаар “Хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой журам” батлагдсан. Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах 29 Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2020 оны эхний 1 дүгээр улиралд нийт 928 иргэнийг хамгаалалтад авсны 367 нь хүүхэд байна.
	21.1.3. хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх тусгай утасны үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах;	Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийг байгуулж, 24 цагаар дуудлага мэдээлэл хүлээн авч, зөвлөгөө мэдээлэл өгөх, холбон зуучлах, хариу үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2019 онд 100,904 дуудлага ирсний, 18.192 нь хүүхэд хамгааллын дуудлага байсан ба кейс шийдвэрлэлт 78%, 22%д нь Хамтарсан багууд үйлчилгээ үзүүлж байна.



		21.1.4. хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;	Сум, хороо, багийн хамтарсан баг, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, хүүхэд хамгааллын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн, өртөж болзошгүй нөхцөл байдалд байгаа хүүхдэд, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/33 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.
10.	<b>Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай</b> 2018.11.15	12.2. Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайдын А/59 дугаар тушаалаар “Согтуурах мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах журам” “Согтуурах, мансуурах донтой эсэийг тогтоох эрүүл мэндийн дүгнэлтийн загвар”, “Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох биеийн хүнд эмгэгийн жагсаалт”, “Согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх журам” батлагдаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020.02.20-ны өдрийн 4717 дугаарт бүртгүүлсэн. Дээрх журам батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А/58, А/14 дугаар “Тушаал хүчингүй болгосонд тооцох тухай” тушаал батлагдсан.
		13.2. Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХЗДХС-ын 2019.08.01-ний өдрийн А/155 дугаар тушаалаар “Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журам”-ыг баталсан.
		14.2. Албадан эмчлэх эмнэлгийн зардлын жишиг нормативыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ХЗДХС, Сангийн сайдын 2019.06.12-ны өдрийн А/105, 138 дугаар хамтарсан тушаалаар “Албадан эмчлэх эмнэлгийн зардлын жишиг норматив”-ыг баталсан.
11.	<b>Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт оруулах тухай</b> 2016.12.28	7.4. Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХЗДХС-ын 2017 оны А/49 дүгээр тушаалаар “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг батлан мөрдөж байна.
12.	<b>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай</b> 2017.05.18	14.6. Гэмт хэргийн тухай мэдээллийн төлбөрийн жишгийг санхүүгийн болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Монгол улсын Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-297, 360 дугаар тушаалаар “Иргэд байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-ийг баталсан.
13.	<b>Улсын бүртгэлийн ерөнхий хууль</b> /Шинэчилсэн найруулга/ 2018.06.21	12.12. Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг холбогдох Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.	Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 220 дугаар “Журам батлах тухай” тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам” батлагдсан.

14.	<b>Иргэний бүртгэлийн тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2018.06.21	5.9. Энэ хуулийн 5.5-д заасан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх журмыг улсын бүртгэлийн болон гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. <i>/5.5.Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар /цаашид “Дипломат төлөөлөгчийн газар” гэх/-ын бүртгэлийн ажилтан нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.8, 6.1.9, 6.1.10, 6.1.11-д заасан иргэний улсын бүртгэлийг хөтөлнө./</i>	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/2381, А/115 дугаар тушаалаар “Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт хөтөлсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичиг хүргүүлэх журам” батлагдсан.
15.	<b>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2018.06.21	5.4. Энэ хуулийн 5.3-т заасан эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний загвар, гэрчилгээнд тусгах мэдээлэл, гэрчилгээ олгох журмыг Засгийн газар батална. <i>/5.3.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 5.1-д заасан өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэснийг нотолж эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно./</i>  33.3. Нотариатчийн энэ хуулийн 33.1-д заасан үйл ажиллагааны журам, энэ хуулийн 35.1-д заасан гэрээний загвар, энэ хуулийн 34.1.5-д заасан сургалтын болон энэ хуулийн 35.1.3-т заасан мэдээллийн сан ашигласны төлбөрийн хэмжээг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/33.1.Нотариатч улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхэлнэ:          33.1.1.энэ хуульд заасан мэдүүлэг гаргагчийн улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг хуулийн шаардлага хангуулан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах; 33.1.2.энэ хуулийн 33.1.1-д заасан мэдүүлэг илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас авч, энэ хууль болон гэрээнд заасан хүрээнд ашиглах.          35.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 34.1-д заасан шаардлагыг хангасан, хүсэлт гаргасан нотариатчтай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:          34.1.5.сургалтад хамрагдсан байх.          35.1.3.улсын бүртгэлийн мэдээллийн сан ашигласны төлбөр;/</i>	Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 394 дугаар тогтоолоор “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох журам”-ыг баталсан.  Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/22 дугаар “Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам” батлагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/22 дугаар “Журам, гэрээний загвар, төлбөрийн хэмжээ батлах тухай” тушаалын 2 дахь заалтаар нотариатч улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан ашигласны төлбөрийн хэмжээг тогтоосон.

16.	<b>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай</b> /Шинэчилсэн найруулга/ 2018.06.21	7.2. Улсын бүртгэлийн байгууллага гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам” батлагдсан.
		7.3. Улсын бүртгэлийн байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/16, А/07 дугаар тушаалаар “Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам” батлагдав.
		8.4. Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд хөтлөх журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/208 дугаар “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам батлах тухай” тушаалаар батлагдав.
		8.11. Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/216 дугаар тушаалаар “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам” батлагдав.
		13.7. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах талаар иргэн, хуулийн этгээд хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, хязгаарлалт, нэр баталгаажуулахтай холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 339 дугаар тогтоолоор “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” батлагдав.
17.	<b>ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ</b> /Шинэчилсэн найруулга/ Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 2019.06.06	14.3. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Зохицуулах зөвлөлөөс баталсан нийтлэг журамд нийцүүлэн батална.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны “Зохицуулах зөвлөлийн ажиллах журам батлах тухай” 107 дугаар тогтоол батлагдсан. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг мөн өдрийн 108 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.
		32.2. Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ.	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор хулгайлах гэмт хэрэг, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг, зөрчил, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 4 видео контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүтээж, телевизийн эфирээр цацуулах хүсэлтийг МҮОНТВ болон бусад 15 телевизээр үнэ төлбөргүй цацуулж байна.
<b>Нийт 17 хуулийн 80 хэсэг, заалт</b>			

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,  
ХЯНАЛТААС ХАСАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ  
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1.	<b>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</b> 2015.07.09 №76	1.2. Тагнуулын байгууллагын тухай болон холбогдох бусад хуульд заасан дүрэм, журам, эрх зүйн актыг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан баталж мөрдүүлэх.	Тогтоолын дагуу Хилийн тагнуулын газрыг Хил хамгаалах ерөнхий газраас, Цэргийн тагнуулын газрыг Зэвсэгт хүчний жанжин штабаас орон тоо, төсөв, гүйцэтгэх ажилтай холбогдох бие бүрэлдэхүүн, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг, хэрэгслийн хамт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд давхардсан тоогоор Засгийн газрын тогтоол 5, Тагнуулын ерөнхий газрын даргын тушаалаар дүрэм 3, журам 7, заавар 13, бусад байгууллагатай хамтарсан заавар 1, журам 4, болон холбогдох бусад хуульд заасан дүрэм, журам, эрхзүйн актыг хуульд заасан хугацаанд багтаан баталж мөрдүүлсэн.
2.	<b>“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай”</b> 2017.02.10 №23	2. Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлыг яаралтай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.	Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулж байна. Тэдгээр төрийн өмчит үйлдвэрийн газруудыг Засгийн газраас онц байдалд шилжүүлэн хяналт тавин ажиллаж байна.
3.	<b>Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2017.05.18 №34	1.1/ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан шүүх, прокурор болон холбогдох бусад байгууллагын албан хаагч, ажилтан, иргэн, хуулийн этгээдэд хуулиудыг сурталчлан таниулах, сургалт	ХЗДХЯ: Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын ХЗБХороо, Хууль сахиулахын их сургуультай хамтран Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийг 2018 оны 3 сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд хэлэлцүүлгээс гарах зөвлөмжийн төслийг ХЗБХ-той хамтран боловсруулсан. Эрүүгийн багц хуулийн хэрэгжилтийн явцад гарч байгаа давхардал, хийдлийг судлах, санал боловсруулах чиглэлээр байгуулагдсан байнгын ажиллагаатай ажлын хэсгийн явцын мэдээлэл хэлэлцэх хуралд оролцож, хурлаас гарсан чиглэлийн дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн явцтай холбогдон гарсан саналуудыг хүлээн авч судалж, ажлын хэсгийн ахлагчид

		<p>зохион байгуулах арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>танилцуулсан. Нийт 7 байгууллага, 2 иргэнээс давхардсан тоогоор 150 гаруй санал ирснийг бүлэглэн нэгтгэсэн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ирүүлсэн саналуудыг хэлэлцэх ажлын хэсгийн хурлыг 2018.05.25-ны өдөр болон 6 сарын 06-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>МХЕГ: Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал”, “Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн гаргасан журам, заавар” болон салбарын бусад хууль тогтоомжоор:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017 онд нийт 15 удаагийн сургалтаар 2150 улсын байцаагч, албан тушаалтнуудыг хамруулан сургалтыг зохион байгуулав.</li> <li>- 2018 онд Төв орон нутгийн Мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын албадын Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын 50, дэд бүтцийн хяналтын 142, Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын 26, Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын 170, Геологи, уул уурхайн хяналтын 30, шинээр томилогдсон 139, хуулиар эрх олгогдсон 40 улсын байцаагч, Сэлэнгэ, Архангай, Завхан, Хөвсгөл, Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Баянгол, Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн 235, Төв, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын МХГ-ын Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын 70, Орхон, Дархан, Сэлэнгэ, Булган, Сүхбаатар боомт дахь ХМХА-дын 130, СХД дэх МХХ-ийн 27 улсын байцаагчид /нийт 1530 улсын байцаагчдыг/ 26 удаагийн танхимын болон онлайн сургалтад хамруулсан. Мөн нийт 472 аж ахуйн нэгж байгууллагын 545 ажилтанд Зөрчлийн тухай, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар сургалт зохион байгуулав.</li> <li>-2019 онд нийт 7 удаагийн сургалтаар 400 орчим улсын байцаагч, албан тушаалтнуудыг хамруулан сургалтыг зохион байгуулав.</li> <li>-2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Төв орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албадын нийт 45 Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан /ахлах/ мэргэжилтнүүдийг чадвахжуулах нь сэдэвт сургалтад оролцогчдод -Захиргааны ерөнхий хууль, захиргааны акт гаргах үйл ажиллагаанд анхаарах асуудал болон Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөв.</li> <li>-“Ази Фарм”-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 150 орчим эм зүйч, эмийн санч нарт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан.</li> <li>“Нийслэлийн нийтийн тээврийн газрын 40 улсын байцаагчдад зөрчлийн тухай, зөрчил шалган шийдвэрлэх тухай болон салбарын бусад хууль тогтоомжоор сургалт зохион байгуулав.</li> </ul>
		<p>1.2/ Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах үүднээс холбогдох хуулийн</p>	<p>ХЗДХЯ: Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг багц хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн,</p>

		<p>төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн Улсын Их Хурал хэлэлцэж 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017.09.25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хоорондын хийдэл давхардлыг арилгах тухай ажлын хэсэгт манай байгууллагаас гишүүнээр орж ажилласан. Мөн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилттэй холбоотой гарч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 40 орчим саналыг 2017.11.24-ний өдрийн 1/3602 дугаар албан бичгээр Шадар сайдад, 2017.12.22-ны өдрийн 1/3895 дугаар албан бичгээр ХЗДХ-ын яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>ХЗДХЯ-наас ирүүлсэн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдэд манай байгууллагаас 2018 онд 01/2372, 01/2373 дугаар албан бичгээр, 2019 онд 01/2421, 01/2422 дүгээр албан бичгээр давхардсан тоогоор нийт 160 орчим саналыг Хууль зүй дотоод хэргийн болон Монгол Улсын Шадар сайдад тус тус хүргүүлсэн.</p> <p>Дээрх саналын хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих, Малын генетик нөөцийн хууль зөрчих, Хог хаягдлын тухай хууль зөрчих, Усан замын тээврийн тухай хууль зөрчих зөрчил, Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль зөрчих зөрчлүүдийн төсөлд бүхэлд нь найруулгаар, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Эрүүл ахуйн тухай болон бусад хуулиудын зөрчилд тулгамдаж байгаа саналуудыг тусгуулж, хууль хоорондын зөрчил хийдлийг арилгав. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд Мэргэжлийн хяналтын байгууллагын шалган шийдвэрлэх зөрчлүүд Гаалийн байгууллагын улсын байцаагчийн харьяалалд давхардаж орсныг хасуулах, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг шалгах хугацаа 3 хоног байсныг 5 болгох, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиас иш татсаныг тусган бичих, албадан ирүүлдэг байх зэрэг саналуудыг хүргүүлж тусгууллаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг дагалдуулан Боловсролын тухай, Эм, Эмнэлгийн хэрэгслийн тухай, Соёлын өвийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж УИХ, ХЗДХЯаман дахь ажлын хэсэгт хүргүүлсэн бөгөөд, УИХ дахь ажлын хэсгийн түвшинд ярилцаж, цаашид хууль тогтоомжийн зөрчил хийдэл, давхардлыг арилгах хүрээнд шийдвэрлүүлэхээр хойшлуулсан болно.</p>
	<p>1.3/ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай</p>	<p>Эрүүгийн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг багц хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн</p>	

		холбогдуулан Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах тухай Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	хуралдаанаар хэлэлцүүлэн, 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан.
4.	<b>Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2018.06.21 №54	1.3. улсын бүртгэлийн багц хуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой нэмэлт зардлыг санхүүжүүлэх.	Улсын бүртгэлийн багц хуулийг олон нийтэд сурталчлах сурталчилгааны ажлын ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. Улсын бүртгэлийн багц хууль болон www.burtgel.mn цахим системийг сурталчилсан тус бүр 60 секундын видео шторкийг мэргэжлийн студид бэлтгэж, 6 телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хуваарийн дагуу олон нийтэд хүргэв. Видео шторкийг news.mn, zaluu.com, ikon.mn, zarig.mn зэрэг мэдээллийн сайтуудад байршуулсан. Улсын бүртгэлийн багц хуулийг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний бүртгэлийн үйлчилгээ болон архивын үйлчилгээний талаар иргэдэд тараах хялбаршуулсан 152 төрлийн 24 694 ширхэг гарын авлага, брошурыг бэлтгэн тараасан. Байгууллагын цахим хуудсыг бүрэн шинэчлэж, 2020.04.01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэв.
5.	<b>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай</b> 2019.06.06 №62	1/а/ “Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенц”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн нэмэлт протокол”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж танилцуулах;	Улсын Их Хурлаас 2020.01.23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаагаа явуулах гишүүн, түүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжийн чиг үүргийг тусган үндэсний механизмыг бий болгохоор заасан болно. Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн нь аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт /хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр/-нд аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх, нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар шилжүүлж, олон нийтэд мэдээлэх чиг үүрэгтэй байхаар тусгасан болно.
		1/б/ хүний эрх, шударга ёсыг хангах хууль хяналтын байгууллагын алба хаагчид хууль тогтоомжоор олгосон эрхээ хэтрүүлж, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хараат бусаар мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах бие	Засгийн газраас 2017 оны 2 дугаар сард Эрүүгийн багц хуулийг боловсронгуй болгох зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад уг хуулийн төсөлд “Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг сэргээх асуудал”-ыг нэмэх зарчмын санал гарч анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч эцсийн хэлэлцүүлгээр уг саналыг дэмжээгүй байна. Хүний эрхийн

		<p>даасан байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж танилцуулах;</p>	<p>үндэсний комисс болон олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд 2019 оны 12 дугаар сард Улсын Их Хурлын даргын захирамжаар “Тусгай субъектуудын үйлдсэн хэргийг харьяалан шалгах бүтцийг хэрхэн байгуулах талаар судлах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p>
		<p>1/в/ эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх сургалтыг шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж, сургалтыг тогтмолжуулах, хүний эрхийн чиглэлээр сургалтад тогтмол хамруулах;</p>	<p>“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу давтан болон мэргэшүүлэх сургалтад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх гэмт хэргийн талаарх тусгайлсан сургалтыг ХЭҮК болон хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчдаар тогтмол зохион байгуулж ажилласан.</p> <p>ХЗДХЯ, Азийн сантай хамтран олон улсын төслийн хөрөнгөөр 2019 онд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт сургалтад сургагч багшаар тус хэлтсээс 2 алба хаагч бэлтгэгдэж, Цагдаагийн байгууллагын нийт 280 орчим алба хаагч нарт бүсчилсэн сургалт зохион байгуулж үр дүнг тооцсон.</p> <p>“Анбаунд Монгол” ТББ-тай хамтран Америкийн Нэгдсэн Улсын Техас мужийн Векон хотын Цагдаагийн газрын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх газрын төлөөлөл ирж цагдаагийн байгууллагын 19 нэгжийн 49, прокурорын байгууллагын 13 нэгжийн 19, нийт 68 ажилтан, алба хаагчдад онол, практикт суурилсан 13 цагийн сургалтыг 2019 онд зохион байгуулсан.</p> <p>ЦЕГ-ын даргын 2020 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2020 оны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Удирдах ажилтныг чадавхжуулах сургалт”-ыг энэ оны 04 дүгээр сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, “Хүний эрхийн тухай ойлголт, олон улсын гэрээ конвенц”, “Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх нь”, “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт”, “Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэглэх нь”, “Хүний эрх ба цагдаагийн байгууллагын оролцоо” зэрэг 5 сэдвийг тусгасан. Цахим сургалтад цагдаа, дотоодын цэргийн 42 анги, байгууллагын 508 удирдах ажилтан, нөөцөд авагдсан алба хаагч хамрагдахаар нэрс ирүүлснээс 45 байгууллагын 493 /газар, хэлтсийн дарга 69, тасаг, хэсгийн дарга 265, нөөцөд авагдсан 159/ алба хаагч хамрагдсан.</p>
		<p>2/б/ аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх шинэ төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох;</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар, УИХ-ын чуулганы 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, уг хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн болно. Энэхүү хуулийн төсөлд насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандартыг бий болгох, насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлэх тусламж үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг нэмсэн.</p>



	<p>2/в/ хүүхдийн эсрэг гэмт хэрэг, <b>хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй</b> байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээнд гарч байгаа зардлыг төр бүрэн хариуцдаг байх, хохирогчийг дэмжих сан байгуулахад анхаарах;</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/263, А/406, 321 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалаар “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ын гуравдугаар зүйлд “Насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна”, дээрхи тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Шүүх эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний Цогцост хийх шинжилгээний хэсгийн 5-д заасан “Цогцост хийх шинжилгээ /0-18 насны/-30000” гэснийг хүчингүй болгосугай.” гэж тус тус өөрчлөлт оруулсан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын батлагдсан төсөвт хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээний зардал тусгагдаагүй бөгөөд Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын хүрээнд ажиллаж байна. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйл /Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа/-ийн 18.2.5-д “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрдсэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актад хохирогчийг дэмжих сан байгуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар цагдаагийн байгууллагад хариуцуулсан, эрх, үүрэг хүлээлгэсэн заалт байхгүй байна.</p>
	<p>2/г/ хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, аливаа хэлбэрийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдээллийн талаарх сургалтыг хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах;</p>	<p>Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, аливаа хэлбэрийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдээллийн талаарх сургалтыг хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах зорилгоор “Дрем” телевизтэй хамтран Бонго, Мажухын найзын дүрээр Сэргийлэгч хүү, Сэргийлэгч охины адал явдал бүхий цуврал богино хэмжээний хүүхдийн киног бэлтгэн “Нууцаа хамгаал”, “Танихгүй хүнээс болгоомжил”, “Аюулгүйн зөвлөмж” зэрэг 70 удаагийн дугаарыг бэлтгэн, 7 хоногт 5 удаагийн давталттай, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн цахим болон фейсбүүк хуудас, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв болон Нийслэлийн цагдаагийн удирдах газрын цахим хуудсанд тухай бүр байршуулсан.</p> <p>“Хүүхдийн хөгжил, хамгаалал” төрийн бус байгууллагатай хамтран гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсон 10 хүүхэд, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч нартай уулзаж, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулах, нийгэмшүүлэх зорилгоор сургалтанд хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн харилцааны сөрөг хандлага, хүчирхийлэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, эерэг мэдээллийг өгч хүчирхийллийг тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны 11 дүгээр сарын 21-</p>

			<p>ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Ойлгоё, Хүндэлье” урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан.</p> <p>“Хүүхдийн дуу хоолой” чуулганыг хүүхдийн эрхийн хэрэгжилт, хамгаалал дахь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх, орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх” зорилгын хүрээнд Чингэлтэй дүүргийн 12 ерөнхий боловсролын сургуулийн 150 сурагч, нийгмийн ажилтнуудын дунд “Хүүхдийн эрхийг хангахад тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.</p> <p>Мөн Европын холбоо, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран 2020-2021 онд хэрэгжүүлэх “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооё” төслийн төлөвлөгөөнд цагдаагийн байгууллагаас тусгуулах саналыг боловсруулж хүргүүлсэн.</p> <p>Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран энэ оны 09 дүгээр сард хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар уулзалт хийж, хийж хэрэгжүүлэх ажил, санхүүжилтийг шийдвэрлүүлээд байна.</p>
		<p>2/д/ сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалтыг бууруулах чиглэлээр хүүхэд, насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэргийн сүүлийн 3 жилийн судалгаанд үндэслэн 2019 онд “Хүүхэд хамгаалагч” төслийг нийслэлийн 152 хороо, 21 аймгийн сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн судалгааг хийн, холбогдох байгууллагад танилцуулан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 702.398.220 төгрөгийг шийдвэрлэж, төслийг хэрэгжүүлсэн.</p> <p>Улсын хэмжээнд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч болзошгүй эмзэг цэгүүдийн судалгааг гарган, “Хүүхэд хамгаалагч” эргүүлийн ажиллах цаг, чиглэлийг хороо, баг тус бүрээр тооцон, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд зөвлөмж, зааварчилга өгч, нийт 454 дунд сургуулийн 123.200 сурагч 20.900 эцэг, эх, 3400 багш, ажилчдад мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян арга хэмжээний мэдээ, мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн “Амрыг эрье” нэвтрүүлэгт 4 удаа, МҮОНРТ, UBS, TV5, ТВ8, VTV, Ийгль, ТВ9, Монгол HD, орон нутгийн Саян, Дербес, Шинэ Завхан, Тусгал-1, TBS, Номин, Төв зэрэг телевизүүдэд давхардсан тоогоор 65 удаа, цахим сайт “Medee.mn”, “Zugii.mn”, “Untsug.mn”, “News”, “Арслан.мн”, “Zaluu.mn” зэрэг цахим 8 сайт, өдөр тутмын 6 сонинд ярилцлага, мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэвлэл, мэдээллийн төв, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн цахим сайтаар 85 удаагийн давтамжтай мэдээ, мэдээлэл түгээж, иргэд, олон нийтэд сурталчилж ажилласан.</p> <p>Хүүхдийн аюулгүй байдал, хүмүүжил, төлөвшлийн талаар 8 сэдвийн хүрээнд сургалтын материал, мэдээлэл бэлтгэн 16 их, дээд, 98 ерөнхий боловсролын сургууль, 648 аж,</p>

			<p>ахуйн нэгж, байгууллагын нийт 59.896 сурагч, оюутан, эцэг, эхийн төлөөлөл, ажилчдад 150 удаагийн сургалт, 13 зөвлөгөөн, 6 хэлэлцүүлэг, 25 өдөрлөг зохион байгуулж, 8.600 аж ахуйн нэгж, байгууллага болон нийтийн тээврийн 60 автобусанд 26 төрлийн гарын авлага, 77 төрлийн зурагт хуудас, 56 төрлийн санамж, сэрэмжлүүлэг 21.836 ширхэгийг байршуулсан. Цагдаагийн байгууллагаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн эмч, Дэлхийн зөн орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн аймаг дахь салбаруудтай хамтран дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх, хамгаалах талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан ажил зохион байгуулахад зарцуулагдах 10.000.000 гаруй төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, зарцуулсан байна. Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд энэ талаар тусган батлуулсан.</p>
		<p>2/е/ үндэстний болон хэлний цөөнх хүүхдийн төрийн албан ёсны хэлээр сурч боловсрох эрхийг хангах, сүм, хийдэд шавилан сууж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, унаач хүүхэд, мал маллаж байгаа хүүхдийн сурч боловсрох эрхийг хангасан бодлого, үйл ажиллагаа, зарцуулагдах төсөв хөрөнгийг нэн тэргүүнд шийдвэрлэх;</p>	<p>Хурдан морь уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, мэнд аюулгүй байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээн, сунгаан зохион байгуулахыг хориглосон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хурдан морь уралдаанч хүүхэд, сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тайланг холбогдох газруудад хүргүүлж, танилцуулсан. Судалгаагаар сүм хийдэд шавилан сууж буй хүүхдэд ерөнхий боловсролын хичээлийг оруулдаг байх, хурдан морь уралдаанч хүүхдийг сургууль завсардалт, хичээлийн хоцрогдол их байдаг гэсэн дүгнэлт гарсны дагуу холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв” нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, сэргээн засах, хоёрдогч хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хамт олонд түшиглэн хөгжүүлэх, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, нийгмийн болон эрүүл мэндийн сэргээн засах амбулатори, стационарийн үйлчилгээг үзүүлж байна.</p>
		<p>2/з/ хүүхдийн бэлгийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий боловсролын сургуулийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах арга замыг тодорхойлж, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг, итгэлийг нь хүлээдэг тогтолцоог сургуульд бүрдүүлэх;</p>	<p>БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын 2018 оны А/004, А/01 хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Эрүүл мэнд"-ийн сургалтын хөтөлбөр боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар батлуулан ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж эхэллээ. Ерөнхий боловсролын сургуулийн эмч болон багшийн албан тушаалын тодорхойлолтод хүүхдийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг байх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлыг тодорхой тусгаж, сургууль бүр энэ чиглэлээр график гарган үзлэг хийж, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан.</p>

			<p>2019 оны хичээлийн жилд эрт илрүүлгийн сүрьеэ, БЗДХ, ДОХ, хорт хавдар зэрэг 6 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээнд оюутнуудыг оршин суугаа газрын харьяалал харгалзахгүй хамруулах ажлыг зохион байгуулж, нийт шинээр элсэгчдийн 90 гаруй хувь нь хамрагдсанаас 54 гаруй хувь дотуур байранд амьдардаг оюутнууд байсан. ЭМ-ийн сайд, БСШУС-ын сайдын 2019 оны 1 дүгээр сарын А/87, А/112 дугаар тушаалаар “Оюутан, суралцагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарим арга хэмжээний тухай” Эрт илрүүлгийн 6 төрлийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах боломжоор ханган 2019 оны эцсийн байдлаар нийт оюутны 90 гаруй хувь нь хамрагдсан.</p>
		<p>2/к/ гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсонтой холбоотой хүүхэд сэтгэлзүйн гүн хямралд орж, улмаар амиа хорлох байдалд хүрч байгааг онцгойлон анхаарч гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлдэггүй байх арга хэмжээг авах;</p>	<p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Хүүхдийн эрхийг хангах” /код 316/, “Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ” /код-317/, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хувь хүний нууцлалыг чанд хадгалах, хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх талаар Монголын Үндэсний Олон нийтийн радио, Ханнс Зайделийн сантай хамтран 8 цуврал нэвтрүүлэг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсонтой холбоотой хүүхэд сэтгэлзүйн гүн хямралд орж, улмаар амиа хорлох байдалд хүрч болзошгүй байгааг онцгойлон анхаарч гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй, хүүхэд хохирсон, холбогдсон онцлог хэргүүдийн мэдээллийг ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвөөс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх” /код 201/-ын дагуу иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.</p>
		<p>2/м/ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль тогтоомжийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр сурталчлах, хүүхдийн эрх, <b>хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй</b> байдалтай холбоотой өөрчлөлтийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>ХЗДХЯ-аас хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг багц хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 2019.09.17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болно. Хуулийн төслийг УИХ-ын 2020.01.10-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Эрүүгийн болон Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд тусгагдсан хүүхдийн эрхийг зөрчих зөрчлийг Хүүхэд хамгааллын тухай болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн томьёолж, хүүхдийн эрхийн эсрэг зарим үйлдэлд Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр болсон. Мөн Эрүүгийн хуулийн Арван зургадугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгайлан зааж өгсөн бөгөөд Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах /16.1 дүгээр зүйл/, Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах /16.2 дугаар зүйл/, Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх /16.3 дугаар зүйл/, Хүүхдээр гуйлга гуйлгах /16.4 дүгээр зүйл/, Хүүхэд солих /16.5 дугаар зүйл/, Хүүхэд худалдах /16.6 дугаар зүйл/, Хүүхэдтэй хэрцгий</p>

		<p>харьцах /16.7 дугаар зүйл/, Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах /16.8 дугаар зүйл/, Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах /16.9 дүгээр зүйл/, Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх /16.10 дугаар зүйл/, Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/16.11 дүгээр зүйл/ зэрэг үйлдлийг хүүхдийн эсрэг гэмт хэрэгт тооцсон байдаг болно.</p> <p>2020.01.10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүчиндэх /12.1 дүгээр зүйл/ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн бол хоёроос найман жил хүртэл хорих ялтай байсныг таваас арван хоёр жил хүртэл хорих ялтай болгож, арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгож үйлдсэн бол таваас арван жил хүртэл хорих ялтай байсныг наймаас арван таван жил хүртэл хорих ялтай болгож ялын бодлогыг чангатгав. Мөн Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах /12.2 дугаар зүйл/ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож хоёр жил хүртэл хорих ялтай байсныг 8 хүртэл жил болгож ялыг нэмэгдүүлсэн болно.</p> <p>Биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон бөгөөд энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар зохицуулалт тусгалаа.</p>
	<p>3/б/ ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн байгаа орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгаж, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;</p>	<p>1. УУХҮЯ-нд “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын төсөлд санал боловсруулан 2018 оны 02/3834 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.</p> <p>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2019 оны А/181, А/458 тоот тушаалаар “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг батлан Захиргааны хэм хэмжээ, актын улсын нэгдсэн санд 2019 оны 4530 дугаарт бүртгэгдсэн.</p> <p>Урт хугацааны туршид нөхөн сэргээлт хийх боломжгүй уул уурхайн төсөл хэрэгжүүлж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дүйцүүлэн хамгаалах ажлыг эзэн холбогдогч нь тогтоогдоогүйн улмаас нөхөн сэргээлт хийгээгүй газарт гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, байгаль орчны болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилладаггүй, олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийдэггүй аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэх хариуцлагыг өндөрсгөн тусгай зөвшөөрөл дахин олгодоггүй байх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээ авах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 2019 оны 02/3726, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2019 оны 02/3727 тоот албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж ажиллах тухай 2020 оны</p>

			<p>01/19 тоот тандалт судалгааны удирдамжийг батлуулан аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газруудад хүргүүлсэн.</p> <p>2020 оны ашиглалтын үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнө Өмнөх жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллах талаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 2020 оны 02/409 тоот чиглэлийг хүргүүлсэн.</p>
		<p>5/а/ боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр болон “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг харгалзан үздэг байх;</p>	<p>БСШУСЯ-ны харьяа Боловсролын хүрээлэнгээс 2019 онд дараах бодлогын баримт бичиг болон сургалтын хөтөлбөр боловсруулахад НҮБ-ын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр болон “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилго зорилт, шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж, тусгадаг. Үүнд:</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны А/528 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг баталсан.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан.</p> <p>БСШУС-ын сайдын 2019 оны 11 дугаар сарын 28-ны а/756 дугаар тушаалаар Насан туршдаа суралцахуйг дэмжих хөтөлбөрийг баталсан.</p> <p>Тогтвортой хөгжлийн үзэл санаа, нийгмийн захиалга, хувь хүний хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадварыг иргэдэд нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр тасралтгүй эзэмшүүлэх нөхцөл бүрдүүлэх, насан туршийн боловсролын тогтолцооны чадавхыг нэмэгдүүлж, боловсронгуй болгох зорилгоор 2019-2021 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.</p>
		<p>5/в/ дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, шаардлагад хүний эрхийн боловсролын асуудлыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 02-р хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"-ыг баталсан.</p> <p>Тус шалгуур үзүүлэлтийн 2.1.“Эрх зүйн зохицуулалт” шалгуурт “Сургууль нь нэгж, хамт олон, хувь хүн бүрийн оюуны болон академик эрх чөлөөг хангасан, мэргэжлийн ёс зүй ба шинжлэх ухааны судалгаа, боловсролын үйл ажиллагааны нийтлэг хэм хэмжээнд тулгуурласан, сахилга, хариуцлага, аюулгүй байдлын горимыг тогтоон тодорхойлсон эрх зүйн зохицуулалттай, мөн тодорхой хугацаанд нээлттэй хянан сайжруулдаг байна” гэж оруулсан. Мөн БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019.09.25-ны өдрийн 05 тоот тогтоолоор "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"-ыг баталсан. Тус шалгуур, шаардлагын 7.2.5-д “Суралцагчдын эрүүл мэнд, эрх ашигтай холбогдсон асуудалд суралцагчийн оролцоотой шийдвэрлэсэн байна” гэж заасан.</p>
		<p>5/г/ хууль, эрх зүйн сургалттай их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг заавал судлан үзэхээр тусгаж, багш бэлтгэж, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулахыг дэмжих.</p>	<p>“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа их, дээд сургуулиуд нь дэргэдээ хууль зүйн клиник лабораторитой болж, салбарын хууль эрх зүйн тогтолцоо, өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлагын судалгааг хийж, үр дүнг олон нийтэд танилцуулж, бакалаврын түвшний оюутнуудад “Хууль зүйн клиник 1, 2”, сургалтыг явуулж “Хууль зүйн үйлдвэрлэлийн дадлага” -аар бататгаж байна.</p>

			<p>2019 оныг БСШУСЯ-наас ёс зүйн боловсролын жил болгон зарласны хүрээнд ДБШТөслийн санхүүжилтээр ИДС-ийн удирдлага, багш, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд зэрэг 500 хүнийг оролцуулан “Мэргэжлийн ёс зүй, багшийн соёл” сургалтыг 2019.12.09-ний өдөр зохион байгуулсан. Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг Төрийн өмчийн их, дээд сургуульд “Хүний эрх” хичээлийг мэргэжлийн суурь түвшинд 3 багц цагаар нийт оюутанд заавал судлуулж байна.</p>
		<p>7/а/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах, хянан шалгах, холбогдох дүгнэлт гаргах, хариуцлага тооцох зэрэг асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх хэмжээг нэмэгдүүлэх, ажиллах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн найруулж, өргөн мэдүүлэх;</p>	<p>Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Хүний эрхий Үндэсний Комисст гаргасан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гишүүнийг төлөөлөн ажиллаж буй тухайн чиг үүргийг хэрэгжүүлж буй Комиссын ажлын албаны мэргэжилтний мэдээлэл цуглуулах ажиллагааны явцад эдлэх эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулсан; комиссоос хүргүүлж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэхгүй удаашруулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар шуурхай, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь илэрхий байгаа тохиолдолд албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, аж ахуйн нэгжийн хувьд тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг нь зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах зэрэг хариуцлагын механизмыг бий болгосон.</p>
		<p>7/г/ уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>1. МХЕГ-аас “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай” Зөвлөмж боловсруулан Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдад 2020.02.19-ны 02/438 тоотор, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2020.02.18-ны өдрийн 02/455 тоотор тус тус хүргүүлж, салбарын болон харьяа нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үүрэг чиглэл өгч, хамтран ажиллахыг хүссэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт иргэдийг аюулгүй амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг хэрэгжүүлэх, шинэ хандлага, арга барилыг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг бүх хэлбэрээр зохион байгуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэлийг 2020.02.19-ны өдрийн 02/477 тоотор хүргүүлж, салбарын яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрууд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.</p> <p>2. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний дагуу ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, МХЕГ-ын даргын хамтарсан удирдамжийн дагуу 2019 онд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 170 аж ахуйн нэгж байгууллагын 4387 ажлын байр, 20906 ажилтан, 2218 тоног төхөөрөмжид хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлага зохион байгуулалт, ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал,</p>

			<p>баталгаажуулалт, техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилт, албан хаагчдын ажлын байрны нөхцөл, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалтын байдал, дотоодын хяналтын журмыг мөрдөж ажиллуулсан байдал зэрэг 3 чиглэлээр зохион байгуулсан бөгөөд үзлэгийн дүнгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт 69.2 хувь, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал 66.4 хувь, ажлын байрны орчин, нөхцөл 72 хувьтай дүн гарч нэгдсэн дүнгээр ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд 69.8 хувьтай гарсан.</p>
		<p>7/е/ ажиллах нөхцөл, боломжоор барьцаалан дарамтлах, байгууллага, ажил олгогч ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх хэм хэмжээг дотоод журамдаа тусгах, хэрэгжүүлээгүй, эсхүл журмаа зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд тусгах асуудлыг судлах.</p>	<p>Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “бэлгийн дарамт учруулах” үйлдлийг шинээр зөрчилд тооцон тусгайлан зүйл /5.19 дүгээр зүйл/ болгон дараах байдлаар тусгасан болно.</p> <p>Зөрчлийн тухай хуулийн 5.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус тусгасан.</p>
<p><b>Нийт 5 тогтоолын 24 заалт</b></p>			



**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,  
ХЯНАЛТААС ХАСАХ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ  
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1.	<p><b>Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</b> 2010.07.20 №19</p>	<p>1.1/ Төв суурин бүрт мал, мах бэлтгэх цэгийг албан ёсоор тогтоож мал махны гарал үүслийн гэрчилгээг олгох журмыг боловсронгуй болгох, хүсний зах, дэлгүүр бусад газарт борлогдож буй мал, маханд тавих хяналтыг тогтмолжуулах, бүртгэл, мэдээллийн сангаар хяналт тавих энэ ажлын хүрээнд үзлэг, шалгалтыг тогтмол явуулж хэвшүүлэх;</p> <p>1.2/ Малын гарал, үүслийн гэрчилгээг олгох эрх бүхий багийн Засаг дарга, мал эмнэлгийн эмч нарын хариуцлагыг өндөржүүлэх, хууль бусаар олгож байгаа байдлыг таслан зогсоох, зарцуулалтыг тооцдог болох, алдуул болон олдсон малын бүртгэл мэдээллийн санг бий болгоход шаардагдах программ хангамжийн хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх;</p>	<p>Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан махаар хангах зорилгоор 2019 онд Цагдаагийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран ажиллах “Санамж” бичгийг байгуулсан.</p> <p>Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд малын гарал үүслийн цахим санд нэвтрэх программ хангамж бүхий “Таблет” төхөөрөмжийг аймаг, сумдын нийт 44 хяналтын цэгт хүлээлгэн өгч, уг хяналтын цэгүүдээр нэвтэрч буй амьд мал, махны бүртгэл мэдээлэлд цахим сангаас хайлт хийх замаар хяналт тавин ажиллаж байна.</p> <p>“Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дугаар тушаалаар баталсан нийтээр мөрдөгдөх “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 01-р сарын 14-ний 4155 дугаарт бүртгүүлэн улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулан Мал эмнэлгийн гэрчилгээний системийг 22 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын газар, 330 сум, 9-н дүүргийн мал эмнэлгийн тасаг, 1009 мал эмнэлгийн хувийн үйлчилгээний нэгж, 551-н цагдаагийн албан хаагч нарт мал эмнэлгийн гэрчилгээний системд нэвтрэх эрх нээж өгч Улсын хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнийг Мал эмнэлгийн нэгдсэн системээр бүрэн хянах боломжийг бүрдүүлж 2020 онд 83171 ширхэг мал эмнэлгийн цахим гэрчилгээ, 43212 ширхэг мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээг тус тус бичиж олгож, хэрэгжилтэд хяналт тавьж үзлэг, шалгалтыг тогтмол явуулж байна.</p> <p>Швейцарийн хөгжлийн агентлагийн тусламжаар Мал эмнэлгийн ерөнхий газраас хэрэгжүүлсэн “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд “Малын эрүүл мэндийн нэгдсэн систем”-д цагдаагийн байгууллагын “Esearch.police.gov” цахим хуудсыг ашиглан нэвтэрч, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлж, энэ оны 3 дугаар сараас эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Дээрх мэдээллийн санг цагдаагийн байгууллагын алба хаагч өөрийн харьяалах нутаг дэвсгэрт байрлах малчдын хотноос гарах, орох малыг хянах бөгөөд мал хулгайлах гэмт хэрэг гарсан газрын цахим зураглалыг гаргаж, алдагдсан малыг ойр байгаа аймаг, сумдын малын эмч нарт сүлжээгээр дамжуулж мэдээлэх, харилцан мэдээлэл солилцох, сэрэмжлүүлэг өгөх замаар уг гэмт хэргийг шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ашиглах боломжтой.</p>

		<p>Мал эмнэлгийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж Мал эмнэлгийн нэгдсэн систем болон Цагдаагийн ерөнхий газрын Е-патрол системийг нэгтгэн мал эмнэлгийн цахим гэрчилгээг улсын хэмжээнд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Улсын төсөв болон Швейцарын Элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээний хүрээнд 2020 онд Мал эмнэлгийн нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлэхэд 674,831,440.0 төгрөгийн программ хангамж, тоног төхөөрөмж худалдан авч, сургалт зохион байгуулав.</p>
	<p>1.3/ Алдуул малыг бүртгэх, мэдээлэх ажлыг орон нутгийн онцлогт тохируулан журамлаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн малын хулгайтай тэмцэх сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хуримтлал бий болгох ажлыг зохион байгуулах;</p>	<p>ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны А/501 дүгээр тушаалаар батлагдсан “Малын бүртгэлийн журам”-ын 3.5 дахь хэсэгт Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх тухай журмын зүйлийн 3.5.3, 3.5.5 заалтын дагуу мал, амьтан өмчлөгч харьяа сум, дүүргийн Хөдөө аж ахуй тасгаас Алдуул болон хулгайлагдсан малын нотлох тодорхойлолтыг авахаар тусган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Цагдаагийн байгууллага, “Монгол малчин” мэдээллийн агентлагтай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн дагуу “Малчин лавлах 109” төвд иргэдээс ирүүлсэн, алдсан болон олдсон малын талаарх мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор энэ оны 02 дугаар сард 21 аймгийн нийт 365 сумын Засаг даргын Тамгын газрын байранд мэдээллийн самбар байрлуулан, цагдаагийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг өгч, хамтран ажиллаж байна. ХХААХҮЯ-наас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019.12.25-ны өдрийн А/501 тоот тушаалаар “Малын бүртгэлийн журам”-ыг батлуулж, журмын 3.5 дахь хэсэгт “Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх” талаар тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	<p>1.5/ Малын хулгайн эсрэг тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах нөхөрлөл, холбоог төрийн бодлогоор дэмжиж урамшуулах, гэмт хэргийн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдээс мэдээллийг төлбөртэй авах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр малчид, мал бүхий иргэдэд хууль тогтоомжийг сурталчилах;</p>	<p>ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Хэвлэл, мэдээллийн төвөөс 2019 онд “Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал”-ын талаар мэдээлэл бэлтгэж “MNTV”, “TV-5” зэрэг телевизээр нэвтрүүлсэн. Мөн Эрүүгийн цагдаагийн албаны “Criminal.police.gov.mn”, Facebook олон нийтийн сүлжээн дэх “Эрүүгийн цагдаагийн алба” цахим хуудсанд байршуулснаар 1715 иргэн мэдээллийг үзсэн байна. “Мал сүргийг Хулгайн гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэг” ТББ-тай хамтран, мал хулгайлах гэмт хэргийн нийгэмд учруулж буй хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт халдлагаас хамгаалах, уг гэмт хэргийг бууруулах чиглэлээр энэ оны 03 дугаар сарын 05-ны өдөр телевизийн нэвтрүүлэг бэлтгэж, мал хулгайлах гэмт хэргийн 2019 он, 2020 оны эхний 2 сарын нөхцөл байдал, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийсэн.</p> <p>Өмнөговь, Дундговь, Төв, Хэнтий, Архангай, Булган зэрэг 6 аймаг, 11 сумдын нутаг дэвсгэрт орон байрны хулгайн 56 гэмт хэрэг, мөн Төв аймгийн Өндөрширээт, Алтанбулаг, Лүн сумын нутаг дэвсгэрээс 6 удаагийн үйлдлээр 13 тооны бод малыг буудаж, хулгайлсан нэр бүхий 3 этгээдийг илрүүлэн шалгаж байгаа талаар “Өнөөдөр” сонины 2020.04.20-ны өдрийн дугаарт мэдээлэл нийтлүүлсэн.</p>
	<p>1.7/ Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хууль бусаар тууварласан, тээвэрлэсэн,</p>	<p>Улсын Их Хурлаас 2017.05.01-ний өдөр батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийг “мал, мах бэлтгэлийн зориулалтаар мал эмнэлгийн гэрчилгээгүй мал тууварласан, эсхүл мал, мах тээвэрлэсэн, борлуулсан, бэлтгэсэн”, мөн зүйлийн 1.2 дахь хэсгийг “мал эмнэлгийн гэрчилгээ олгох эрх бүхий мал эмнэлгийн ажилтан хуурамч, зөрүүтэй,</p>

		<p>бэлтгэсэн мал, махыг болон зөрчил гаргахад ашигласан уналага, тээврийн хэрэгслийг хураах шийтгэлийг ногдуулах субъектыг тодорхой болгож, зөрчлийг илрүүлсэн орон нутгийн төсвийн орлого болгох ажлыг эрчимжүүлж иргэдэд сайтар сурталчлах;</p>	<p>дууу мэдээлэл оруулсан, эсхүл мал эмнэлгийн гэрчилгээний тухай мэдээллийг цахим санд оруулаагүй хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.</p> <p>Мал хулгайлах гэмт хэрэг 2019 онд 1.683 бүртгэгдсэн, өмнөх оноос 702 нэгжээр буюу 71.6 хувиар өссөн, нийт гэмт хэргийн 5.6 хувийг, орон нутагт бүртгэгдсэн хэргийн 15.6 хувийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.</p> <p>Хүлээн авсан гомдол, мэдээллийн 86.7 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж дугаар авсан бол, бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан 1.583 мал хулгайлах гэмт хэргээс 599 хэргийг илрүүлж, илрүүлэлт 37.8 хувьтай өмнөх оноос 3.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгчдийн 90 гаруй хувь нь малыг нядалж, махыг зах зээлийн үнэ ханшаар зарж борлуулж ашиг олох зорилгоор малыг хулгай хийж махны хэрэгцээ өндөр төвлөрсөн суурин газруудад зарж борлуулж байна.</p> <p>Нийслэлийн СХД-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах “Эмээлт” орчимд тус хэлтсийн алба хаагчид 2020 оны 1 дүгээр улиралд тандалт судалгаа хийж ажиллахад “Саян уул” махны үйлдвэрээс бусад үйлдвэрийн үйл ажиллагаа эхлээгүй зогсолтын байдалтай байв.</p>
		<p>1.11/ Мал, мах бэлтгэх үйлдвэр, мал, мах түүхий эд худалдан авч борлуулдаг зах, цэгүүд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай нутгийн захиргааны байгууллага гэрээ хийж, мал, мах бэлтгэн нийлүүлэгчид, ченжүүдийг нэгдсэн бүртгэлд хамруулан тусгай зөвшөөрөл өгсний үндсэн дээр мах бэлтгүүлэх, бүртгэлийг үндэслэн орон нутгаас тээвэрлэх, тууварлах журмыг боловсруулах;</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.07.18-ны өдрийн А/135 тоот тушаалаар “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд тус хуулийн төсөлтэй уялдуулан мал, мах бэлтгэн нийлүүлэгчид, ченжүүдийг нэгдсэн бүртгэлд хамруулах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журмын төслийг боловсруулан, бэлтгэл ажлыг хангасан.</p> <p>2019 онд мал нядлах үйл ажиллагаа явуулдаг 6 иргэн 19 аж ахуйн нэгж, нийт 25 газар хамрагдсанаас судалгаанд хамрагдсан 24, судалгаанд хамрагдаагүй 1 шалгаж БНХАУ-ын иргэд, аж ахуйн нэгжээс махны үйлдвэрийн хөлдөөх агуулахыг түрээсэлж мах бэлтгэж нөөцөлсөн “Үүлэн гөү” , “Шилүүст сүмбэр”, “Саян хатан трейд”, “Хадатын ундарга”, “Бөжт”, “Тэнүүн хүсэл” ХХК зэрэг 6 газрын үйл ажиллагааг түр зогсоож, хонины 522, ямааны 180,5, үхрийн 160, адууны 286, нийт 1159 тонн махыг МХЕГ-ын алба хаагчид лацдаж битүүмжилсэн ба шалгалтын явцад малыг зүй бус аргаар төхөөрч байгаа байдал тогтоогдоогүй болно.</p> <p>Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ын хүрээнд мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг улсын хэмжээнд олгож малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавин аймаг, орон нутгийн замын хяналтын пост болон бусад шаардлагатай постуудад ажиллаж байгаа алба хаагч нар хэрэгжилтийг хангуулж, мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэж явсан 4.900 орчим тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 295 зөрчлийг илрүүлэн, зөрчил гаргасан 285 иргэнийг 42,505,000 төгрөгөөр торгож ажилласан ба мал хулгайлах гэмт хэрэгт шууд бус хэлбэрээр оролцсон 21</p>

			этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэж, 16 этгээдийг эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгаж байна.
		1.12/ Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах мал, мах, түүхий эдийн “Эмээлт”, Налайх дүүрэгт байрлах “Цайз” захуудад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр улсын мэргэжлийн хяналтын байцаагч байнга ажиллуулах, мөн цагдаагийн хэсэг байгуулан ажиллуулах, ажлын байр, орон тоо, төсвийн асуудлыг шийдвэрлэх.	Мал, малын гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт, худалдаа болон мал нядлагааны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр 2019 оны 03 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Нийслэл хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Эмээлт” “Хүчит шонхор”, “Нарантуул-2” зэрэг зах, худалдааны төвүүдэд шалгалт хийж ажилласан.
2.	<b>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай</b> 2012.01.17 №21	1.4/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын сонгон шалгаруулалт, мэдлэг, ур чадвар, харилцааны соёл, мэргэжлийн ёс зүйн хувьд анхаарах шаардлагатай байгаа тул хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгох;	<p>ШШГЕГ нь хүний нөөцийн бодлогыг боловронгуй болгохоор чиглэлээр тухай бүр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд 2019-2020 онд дараах ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд: -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2020 оныг “ШШГБ-ын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах жил” болгон зарлаж, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШШГЕГ-ын даргын 2019.02.28-ны өдрийн А/38 дугаар тушаалаар “ШШГБ-ын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” (2020-2024) болон хүний нөөцтэй холбоотой журам, зааврыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>-ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачид болон Хүний нөөцийн хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2019.12.10-2020.02.10-ны өдрүүдэд судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>- Хамтарсан судалгааны багийн зөвлөмж, дүгнэлтэд суурилан ШШГБ-ын Хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулж, удирдлагад танилцуулсан.</p> <p>- ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам, хүний нөөцийн журмыг тус тус шинэчлэн боловсруулж, харьяа алба, хорих анги, салбар нэгжүүдээс журамд тусгах санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>-Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2019.11.07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар "ШШГБ-ын алба хаагчдад 2019-2020 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр", ШШГЕГ-ын даргын 2020.03.05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар “ШШГБ-ын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг тус тус батлан, анги, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>ШШГЕГ, “Азийн сан”-тай хамтран ШШГБ-ын алба хаагчдын ёс зүй, хандлагыг хөгжүүлэх чиглэлээр “Ёс зүйн сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулж, ёс зүйн чиглэлээрх</p>

			хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлагыг боловсруулж, анги, нэгжийн алба хаагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтад 11 алба хаагч хамрагдсан.
		1.11/ Нэр бүхий Хадгаламж, зээлийн хоршоодын хохирогчдын хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэсэн хувьцаат компаниудын хөрөнгийг битүүмжлэлээс гаргаж, төлбөр төлөгчдийн тус компаниудад зөвхөн эзэмшиж байсан хувьцааг зохих хууль тогтоомжид нийцүүлэн худалдан борлуулж хохирогчдын хохирлыг барагдуулах талаар арга хэмжээ авах;	Дампуурсан, татан буугдсан хадгаламж зээлийн хоршоодод холбогдох гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төвлөрүүлсэн 855.7 сая төгрөгийг хохирогчдод хуваарилах асуудлыг “Ажлын хэсэг”-ийн 2020.04.07-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 792.8 сая төгрөгийг 657 хохирогчид хуваарилсан. 2020 онд 1 дүгээр улирлын байдлаар татан буугдсан, дампуурсан банкны нэхэмжлэлтэй биелүүлбэл зохих 158 гүйцэтгэх баримт бичгийн 2.9 тэрбум төгрөгөөс 14 гүйцэтгэх баримт бичгийн 1.2 тэрбум төгрөгийг биелүүлж, 144 гүйцэтгэх баримт бичгийн 1.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн 8.9 хувийг биелүүллэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 2.7 хувиар өссөн байна.
		1.12/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг харилцаа холбоо, мэдээлэл, технологийн дэвшилт системд нэвтрүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг иргэний бүртгэлийн нэгдсэн системд нэвтрэх нөхцлийг бүрдүүлэх, шүүх байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбож, мэдээлэл харилцан солилцох боломжийг бүрдүүлэх талаар судалж, шийдвэрлэх;	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч талуудын холбогдох мэдээллийг хайх, лавлагааны үйл ажиллагааг сайжруулах, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн болон эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн мэдээллийн тодруулж цахимаар мэдээлэл солилцох зорилгоор УБЕГ-аас иргэн, хуулийн этгээдийн 6 төрлийн 53 мэдээллийг цахим хэлбэрээр авч, эрх бүхий албан тушаалтнуудад нэвтрэх эрхийг олгож дотоод үйл ажиллагаандаа ашиглаж байна. Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн сан харилцан солилцох журмын дагуу “Хорих болон хорихоос өөр төрлийн цахим бүртгэлийн нэгдсэн систем”-ийн сангаас 3 төрлийн 160, 6 төрлийн 42 мэдээллийг нэгдсэн санд дамжуулж, мэдээллийн сангийн баяжилт хийж байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор cdea.gov.mn цахим хуудсаар дамжуулан төлбөр төлөлт болон бусад ажиллагааны талаарх мэдээллийг интернетийн орчинд хүлээн авах боломж нөхцөлийг бүрдүүлэн мэдээллийг талуудад цахимаар хүргэж байна. Уг ажлын хүрээнд гар утсанд зориулсан програмын тусламжтайгаар appstore, playstore-т “ШГА талууд” нэрээр аппликейшн байршуулан үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлбөр төлөгч 4287, төлбөр авагч 17360 иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр мэдээлэл авах эрхийг олгосон. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөрөнгийн мэдээлэл, хугацааны сануулга бүхий алба хаагчдад зориулсан гар утасны аппликейшныг боловсруулан appstore, playstore-т “ШГА мэдэгдэл” нэрээр 2020.03.19-ний өдөр байршуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
3.	<b>“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй</b>	2.2/a/ Хугацаат цэргийн албан хаагчдыг үүрэг ажлаас нь өөр ажил, үйлчилгээ болон аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд албадан хөдөлмөрлүүлэхгүй байх, хэрэв энэ төрлийн ажилд оролцуулах бол сайн дурын шинжтэй байх,	Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2016.09.01-ний өдөр батлуулсан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу Зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээнд байгуулалтын ажилд оруулна” гэж тусгасан. Тус заалтын дагуу Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2018 оны 01

	<p><b>холбогдуулан авах арга хэмжээний тухай</b> 2015.10.01 №28</p>	<p>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгох, хөдөлмөрийн жирийн нөхцөлд ажиллуулах асуудлыг Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачилж өргөн мэдүүлэх;</p>	<p>дүгээр зарлигаар, “Автозамын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах түр журам”-ыг сайдын 2018 оны А/179 дүгээр тушаалаар батлуулсан. Сангийн сайд, Батлан хамгаалахын сайдын хамтарсан 2020.02.07-ны өдрийн А/39/28 дугаар тушаалаар бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа хугацаат цэргийн алба хаагчдад олгох томилолтын зардлын хэмжээг тогтоон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Батлан хамгаалахын сайдын 2019 оны.... дүгээр тушаалыг үндэслэн ЗХЖШ-ын даргын “Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах тухай” 2019 оны .....дугаар тушаалаар 9 төрлийн 18 мэргэжлээр бэлтгэл офицер ..., 9 төрлийн 37 мэргэжлээр түрүүч, байлдагч ....., цэргийн анхан шатны бэлтгэлээр хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн ..., нийт ..... бэлтгэл үүрэгтэнг 2019 онд сургаж бэлтгэсэн байна. (дугаар нууц) ХНХ-ын болон Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан 2020.02.28-ны өдрийн А/70-58 дугаар тушаалаар “Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар, эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам”-ыг баталсан.</p>
		<p>2.4/г/ Монгол Улс “Эрүүдэн шүүх хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт протокол”-ыг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсантай холбогдуулан МУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн нөхцөлийг бодитойгоор бүрдүүлэх;</p>	<p>Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаагаа явуулах гишүүн, түүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжийн чиг үүргийг тусган үндэсний механизмыг бий болгохоор заасан болно. Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн нь аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт /“хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр/-нд аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх, нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар шилжүүлж, олон нийтэд мэдээлэх чиг үүрэгтэй байхаар тусгасан болно.</p>
<p>4.</p>	<p><b>“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай</b> 2015.10.01 №29</p>	<p>4.а/ Төрөлжсөн асрамжийн газрын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээг шинэчлэн тогтоож, нөхцөл, үйл ажиллагааг нь сайжруулах санал боловсруулж танилцуулах;</p> <p>4.ж/ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах эрхийг тодорхой гэмт хэрэг мөрдөн шалгадаг байгууллагаас салгаж, сонирхлын</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ Нийтлэг шаардлага, MNS 6517:2017 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар батлуулсан. Тус стандартыг хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн сургалтыг зохион байгуулж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээг МХЕГ, ЦЕГ, ОБЕГ-тай хамтран жил бүр зохион байгуулж хэвшсэн. 2019 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар 31 асрамж халамжийн төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Стандартын хэрэгжилтийн хувь 96 хувьтай байна.</p> <p>Прокурорын байгууллагын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 95 дугаар тушаалаар Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын бүтцэд Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг байгуулж, прокурорын байгууллагаас харьяалал тогтоож ирүүлсэн, шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагчийн үйлдсэн авлига, албан тушаалын гэмт хэргээс бусад гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах чиг үүрэгтэйгээр анх</p>

		зөрчилгүй байгууллагад шилжүүлэх.	байгуулагдсан. Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны А/251 тушаалаар тус хэлтсийг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс болгон өөрчилж, одоогоор хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 2, ахлах мөрдөгч 4, цагдаа 1 орон тоотойгоор ажиллаж байна. Тус хэлтэс нь Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяалал тогтоох тухай” А/33 дугаар тушаалаар баталсан харъяаллын дагуу цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн ажлын байранд үйлдсэн, эрүүдэн шүүснээс бусад гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэг болон шүүгч, прокурорын үйлдсэн /Авилгатай тэмцэх газарт харъяалуулснаас бусад/ гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.
5.	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016.11.16 №10	2.1. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ тайлбар, мэдүүлэг өгөх бүрт байлцах, гэрчийг шүүх хуралд оролцуулахыг шаардах, мэдүүлгийг сонсох зэрэг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөлөөр хангах.  2.4. Төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн орон тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх.	Шинэчлэн баталсан 2017оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1-д “Хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа эрүүгийн хэрэгтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс мэдүүлэг авах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.” гэж заасан нь өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулах нэг баталгаа болж байгаа бөгөөд мөн хуулийн 5.1 дүгээр зүйлд өмгөөлөгчийн эрх, үүрэг, 5.2 дугаар зүйлд өмгөөлөгчийг сонгох, 5.3 дугаар зүйлд өмгөөлөгчийг оролцуулахыг тусгаж өгсөн нь өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн боломж бүрэн бүрдсэн болно. 2016-2019 онд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд давхардсан тоогоор 2766 өмгөөлөгч оролцогч оролцсон.  Хууль зүйн туслалцааны төв нь Хууль зүйн сайд, Сангийн сайдын “Хууль зүйн туслалцааны төвийн орон тоо, салбарын байршлыг шинэчлэн батлах тухай” 2016 оны А/133/437 дугаар хамтарсан тушаалын дагуу 72 орон тоотой ажиллаж байна.  Төв нь 2016 оноос 2020 оны 1 дүгээр улирал хүртэл хугацаанд нийт 12097 эрүүгийн хэргийн 13106 төлбөрийн чадваргүй холбогдогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа буюу өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, 43725 иргэнд хууль зүйн бүх шатны зөвлөгөө мэдээллийг өгсөн байна.
6.	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018.01.31 №02	2.1.1. <b>Нэг.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар</b> Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгаж, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах арга хэмжээ авах.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэх, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэшсэн, цогц байдлаар үзүүлэх зорилгоор Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардалд 2019 онд 8,0 тэрбум төгрөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сум хорооны 608 хамтарсан багийн 4800 гаруй албан хаагчдыг ажлын байран дээр нь чадавхижуулж ажилласан.  Нийгмийн ажилтан бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн боловсролын агуулгыг тусгасан сургалтын модуль, гарын авлагыг боловсруулан, МУИС-ын сургалтын хөтөлбөрт тусгаснаар нийгмийн ажлын болон бусад тэнхмийн 30 гаруй оюутан 2019 оны сүүлийн хагас жилд тус хичээлийг сонгон суралцаж байна.  Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Хүчирхийллийн хохирогчдод нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөөг үзүүлэх” болон “Бэлгийн

			<p>хүчирхийлэлд болон ураг төрлийн хүчирхийлэлд өртсөн охид, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм сэтгэл, зүйн зөвлөгөө өгөх” аргазүйн гарын авлага, сургалтын хөтөлбөр мөн “Хүчирхийллийн хохирогчдод зориулсан нэг цэгийн үйчилгээний төвийн хамтарсан багтай ажиллах, бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээний удирдамж болон үйлчилгээний ёс зүйн зарчим”-ыг боловсрууллаа. Түүнчлэн Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтэс, Хамтарсан баг, Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд ажиллаж байгаа ажилтнуудад жендэр, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийлэлтэй гэр бүлд нийгмийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэхэд зориулан боловсруулсан дээрх гарын авлага, сургалтын хөтөлбөр болон ажлын удирдамж, ёс зүйн зарчмын албан хэрэглээний талаарх сургалтыг Хэнтий, Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл, Дархан-Уул аймгуудаас 300, Нийслэлийн 9 дүүргээс 100 ажилтан, албан хаагчийг оролцуулан зохион байгуулж, нийтдээ 400 ажилтан, албан хаагчийг хамруулаад байна</p> <p>2020 оны төсвийн тухай хуулиар Хүүхэд хамгааллын зардалд 8 тэрбум төгрөг тусгагдсан.</p>
		<p>2.1.3. Өсвөр насны охид эрт бэлгийн харилцаанд орох, хүүхэд төрүүлэх, үр хөндүүлэх, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвдөх нь жилээс жилд нэмэгдэж байгааг онцгойлон анхаарч, энэ чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	<p>“Залуучууд хөгжил 2013-2017” төсөл, Швейцарийн хөгжлийн агентлаг, Льюксембургийн Засгийн газар, НҮБ-ын дэмжлэгтэй Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан хамтран хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийн 16 төвийг аймаг, дүүргүүдэд байгуулсан. Төслийн үр дүнд дээрх төвүүд болон ЕБС-ийн дэргэдэх Амьдрах ухааны танхим, МБСБ-ын дэргэдэх Амьдрах ухааны танхим, эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Өсвөр үед ээлтэй эрүүл мэндийн 28 клиникийн залуучуудад хүргэх амьдрах ухааны боловсрол, тэдний хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл зорилгыг дэмжих, бүтээлч, ёс суртахуунтай иргэн болон төлөвшүүлэх зөвлөгөө, үйлчилгээний чадавхи, нөөц бэхжсэн. Одоогоор бүх аймаг, дүүрэгт Залуучуудын хөгжлийн төв ажиллаж, Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалтад 42500 гаруй залуучуудыг; гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах нөлөөллийн 140 үйл ажиллагаанд 122 гэр бүл, 102 мянга орчим залуусыг; бусдад туслах, урам зориг өгөх, байгаль орчноо хамгаалах 74 нөлөөллийн үйл ажиллагаанд сайн дураар нэгдсэн 12500 гаруй залуусыг; гэр бүлийн зөвлөгөөнд 1400 орчим гэр бүл, залуу хосууд, 400 орчим залуусыг; бүлгийн зөвлөгөөнд 12500 гаруй залуусыг, ганцаарчилсан зөвлөгөөнд 1500 орчим залуусыг жилд хамруулж ажиллаж байна. Мөн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх 112 дэмжих бүлэгт 1700 орчим залуус, 231 сонирхлын бүлэгт 10000 залуучууд хамрагдаж байна. Аймаг, нийслэлийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг бэлгийн цогц боловсролын чиглэлээр мэргэшүүлэх сургалт"-ыг 2018, 2019 онуудад зохион байгуулж нийт 150 гаруй ажилтныг хамруулж чадавхийг бэхжүүлсэн. Сургалтыг МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхим хамтран зохион байгуулж, сэдэв тус болгонд чөлөөт асуулт, хариулт, хэлэлцүүлэг, бүлгийн ажил хийж ажилтнуудын чадавхийг бэхжүүлсэн бөгөөд бэлгийн цогц боловсролын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан тухай гэрчилгээг ажилтнуудад олгосон. Залуучуудын хөгжлийн 32 төв 2018 онд нийт залуучуудын 42 хувь буюу 450 мянга, 2019 онд 28.3 хувь буюу 300 гаруй мянган залуучуудад хүрч үйлчилсэн бөгөөд амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүй, гэр бүлийн боловсрол зэрэг олон талт зөвлөгөө мэдээллийг хүргэлээ. Мөн “Эерэг</p>



			<p>хандлага-эрүүл оюутан” аяныг жил бүр улс даяар зохион байгуулж жилд дунджаар орон нутагт 7000 гаруй оюутан залуучуудыг, нийслэлд 2000 орчим оюутан залуучуудыг хамруулж, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээллийг Өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн кабинетаар болон утсаар хүргэж ажиллаж байна. Түүнчлэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг Улсын Их Хурлаар 2017 онд баталж 2018 оноос хүчин төгөлдөр мөрдөж, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/383 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, эрт төрөлтөөс сэргийлэх мэдлэг, зан үйлийг залуучуудад төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, өндөр эрсдэлтэй эмзэг бүлгийн залуучууд, түүний дотор биеэ үнэлэгч, бэлгийн цөөнх, ажил, сургуульгүй, орлогогүй залууст БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, ХДХВ-ийн нэр хаяггүй сайн дурын шинжилгээ, бэлгийн эрүүл мэндийн зөвлөгөө авах үйлчилгээг зохион байгуулах санаачилгыг дэмжих зэрэг арга хэмжээг салбаруудын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхээр тусгаад байна. Түүнчлэн өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дэмжих үүднээс МСҮТ-ийн эмч, дотуур байрны багш нарын “Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох нь” сургалт, үе тэнгийн багш нарыг бэлтгэх “БЗДХ гэж юу вэ? Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?” сэдэвт сургалт, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, 100 гаруй оюутан залуусыг хамруулж, 40 гаруй үе тэнгийн багш нарыг бэлтгэсэн.</p>
		<p>2.1.7. Төрийн болон хувийн өмчийн тусгай хэв шинжтэй цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, ажилтанд ажлын байрных нь чиг үүргээс хамаарч албан тушаалын үндсэн цалингийнх нь 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгох асуудлыг шийдвэрлэх.</p>	<p>Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын багш, ажилтнуудад үндсэн цалингийн 10-30 хувийн нэмэгдэл хөлс олгож байна. БСШУСЯ-нд ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид нэмэгдэл хөлс олгох тухайд энэхүү журмын хүрээнд хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ажлын ачаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамааран нэмэгдэл хөлс олгох тухай журмыг Боловсролын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах болон нэмэгдэл хөлсний хувь хэмжээг хүүхдийн тооноос хамааран 3-10 хувиар тогтоох тухай санал хүргүүлсэн.</p>
		<p>2.1.8. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилалд байнга асруулж, сувилуулж байгаа хүнд хэлбэрийн болон давхар хөгжлийн бэрхшээлтэй нийт 34 хүүхдийг Өнөр бүл хүүхдийн төвийн харьяанд шилжүүлэх, тухайн байгууллагыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрэн хангах, бүтэц, орон тоог нь</p>	<p>Засгийн газрын 2019 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай” 125 дугаар тогтоолын хавсралтад Засгийн газрын 2020 оны 43 дугаар тогтоолоор тус төвийн дүрэмд “3.3.2. хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлтийн хүрээнд асрамж, халамжийн төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилалд байнга асруулж, сувилуулж байгаа хүнд хэлбэрийн болон давхар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эмнэлэгт суурилсан урт хугацаатай үйлчилгээнд хамруулах 50 ортой тасгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд нээж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/109 дүгээр</p>

		<p>нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.</p>	<p>тушаалаар “Эцэг эх, асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
		<p><b>2.2.1. Хоёр.Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаар</b> Хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, ажилтны үндсэн эрх, зарим нэр томъёог Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хөдөлмөрийн конвенц, зөвлөмж, нийгэм, эдийн засгийн өнөөгийн чиг хандлагад нийцүүлэн Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>Засгийн газраас 2018.03.26-ны өдөр “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, дагалдан гарах бусад хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд УИХ-ын нэгдсэн чуулганаар 2018.04.13-ны өдөр хэлэлцсэн. УИХ-ын даргын 2018 оны 88 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Засгийн газраас өргөн барьсан тус хуулийн төсөлд хуулийн зохицуулалтыг уян хатан болгож, хамрах хүрээг өргөтгөсөн, хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийн тэнцвэржүүлэх, хөдөлмөрийн зах зээлд шинээр бий болсон харилцааг зохицуулсан, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний суурь зарчмууд зэрэг шинэлэг, дэвшилттэй асуудлууд тусгагдсан байна.</p>
		<p>2.3.2. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар, үр дүнтэй мөрдөн шалгах байгууллагыг байгуулах, бүтэц, орон тоог шийдвэрлэх.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 09 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажилласан.</p> <p>Ажлын хэсгээс боловсруулсан хуулиудын төслийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн үеэс эхлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусах хүртэлх үйл ажиллагаанд прокурорын байгууллагаас хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж ажилладаг бөгөөд алба хаагчдаас хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрүү шүүлт тулгах нөхцөл боломжгүй байхаар хуульчилсан.</p> <p>Хүний эрх, шудрага ёсны хэрэгжилтийг хангах хууль хяналтын байгууллагуудад хууль тогтоомжоор олгосон эрхээ хэтрүүлсэн, иргэдтэй зүй бусаар харьцаж Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон эрх, эрх чөлөөг нь зөрчсөн хуулийн байгууллагын алба хаагчтай холбоотой гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, гэмт хэргийг шалгах бие даасан байгууллага байгуулахгүйгээр Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст энэ төрлийн гэмт хэргийн харъяаллыг бүрэн тогтоож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлснээр тус хэлтсийг бие даасан бүтэц болгон цагдаагийн байгууллагын дотоод нөөц бололцоогоор өргөтгөн зохион байгуулж, прокурорын хяналтан дор хэргийг шалгаж, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзсэн.</p>

		<p>3.1. Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомж шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын санаачлан боловсруулсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулахыг удирдлагын зүгээс шийдвэрлэсэн. Хамтарсан ажлын хэсэгт тус яамны ажилтнууд оролцон ажилласан. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2019.06.05-ны өдрийн хуралдаанаараа хийж, 2019.06.06-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p>
		<p>3.2. Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүсэж байгаа тул дээрх хуулиудын зарим зүйл, заалт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэхийг судалж, шийдвэрлэх.</p>	<p>Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн агуулга, үзэл баримтлал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа болно.</p>
		<p>3.3. Хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг зохицуулсан журмыг хүчингүй болгож уг асуудлыг Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>Гэр бүлийн тухай хуулийг 2019 оны 04 сарын 09-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн Наймдугаар бүлгээр “Хүүхэд үрчлэх” асуудлыг зохицуулсан бөгөөд үүгээр гадаад улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх тухай тусгайлан зохицуулсан. Хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” олон улсын /Гаагийн/ конвенцид бүрэн нийцүүлэн Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлд тусгав. Хуулийн төслийг Улсын Их Хуралд 2019.04.08-нд өргөн мэдүүлсэн ба УИХ-ын чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжив.</p>
		<p>3.4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14, 16 дугаар зүйлд заасан дүрэм, журмыг баталж, чиг үүргээ биелүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж, ажиллах.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны эхний 1 дүгээр улиралд “МҮОНРТ”, “TV5”, “UBS”, “TV9”, “MN25” зэрэг 33 телевиз, өдөр тутмын 19 сонин, 45 сайт, 14 FM радиогоор 93 мэдээ, сурвалжлага, зорилтот нэвтрүүлэг, 38 ярилцлага өгсөн ба орон нутгийн радиод 38, сонинд 30, телевизэд 64, урсдаг зард 148 мэдээ, мэдээлэл өгсөн. Мөн 14 фм радиогоор сонсогчдод тогтмол мэдээлэл хүргэж, “UBS” телевизийн “ЦЕГ-мэдээлж байна”, “Ийгл” телевизийн “Бодит байдал” нэвтрүүлэг, “Арслан.мн”, “Zaluu.com” мэдээллийн сайт, МҮОНТ, TV5, TV8, C1 зэрэг телевизтэй хамтран бие даасан 8 нэвтрүүлэг бэлтгэж, үзэгчдэд хүргэсэн.</p>
		<p>3.7. Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагын эрүүл мэндийн ажилтнууд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах, мөн нийгмийн</p>	<p>ЭМЯ, ГССҮТөв санаачлан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор “ОСОЛ, ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2030” салбар дундын шийдвэр гаргагчдын улсын зөвлөгөөнийг 2019 оны 04 сарын 27-ны өдөр зохион байгуулсан.</p>

		<p>эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах үйл ажиллагаа зохион байгуулах.</p>	<p>ЭМЯ, ГССҮТөв санаачлан “ОСОЛ, ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2030” үндэсний хэмжээний салбар дундын улсын чуулганыг 2019 оны 5-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>“Хүүхдийн хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээ, дэмжлэг үзүүлэх ДЭМБ-ын заавар”-ыг танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>“Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах” олон улсын тэмдэглэлт өдрөөр дэлхий нийтээр нийгэмд гэр бүл, бэлгийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг хүн амын мэдлэгийг нэмэгдүүлж, эрх тэгш байдлыг хангах, олон нийтийн оролцоог сайжруулах замаар охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор 12-р сарын 08-ны өдөр Цагдаагийн ерөнхий газар, Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төв, Урлагийн сэтгэл заслын холбоо ТББ -тай хамтран Хүннү моллын урлаг, соёлын танхимд олон нийтэд зориулсан өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн хүрээнд олон нийтэд зориулсан урлаг, соёлын арга хэмжээ, урлагийн сэтгэл заслаар хэрхэн асуудлыг шийдвэрлэх, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлогийн талаар илтгэл, лекц хосолсон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Өдөрлөгт нийт 500 гаруй хамрагдсан.</p> <p>Охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс сэргийлэх өдрийн хүрээнд ДЭМБ-гаас гаргасан 4 төрлийн плакат, 10 төрлийн стикэр наалт зөвлөмжийг орчуулж, нийт 500 ширхэгийг хэвлүүлж иргэдэд тарааж, хүн амын мэдлэгийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог идэвхжүүлсэн.</p>
		<p>3.9. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, гэмт хэргийн тоо улсын хэмжээнд нэгдсэн байдлаар гардаг нэг мэдээллийн санг бий болгож системчлэх, гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар нэгдсэн мэдээлэл, судалгаатай байх.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн санд бүртгэгдсэн насанд хүрээгүй хүн үйлдсэн, холбогдсон, хохирсон гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээллийг сар, улирал, хагас, бүтэн жилээр тогтмол нэгтгэн, шалтгаан нөхцлийг тодорхойлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Энэ оны эхний 04 сарын байдлаар улсын хэмжээнд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 175 бүртгэгдэж, өмнөх оноос 57 хэргээр буюу 24.6 хувиар буурсан. Гэмт хэргийн улмаас 398 хүүхэд хохирсноос 49 хүүхэд нас барж, 113 хүүхэд гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүүхэд 282 буюу 41.5 хувиар буурч, нас барсан хүүхэд 10 буюу 25.6 хувиар өссөн байна.</p>
		<p>3.12. ОХУ, БНХАУ-ын хил залгаа аймаг болох Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цагдаагийн хэлтсийн бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөх, орон тоог нэмэгдүүлэх, дээрх сумдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр бүрэн камержуулах.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/16, А/17 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 2, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Алтанбулаг сум дахь цагдаагийн хэсэгт 1 орон тоог тус тус нэмж шийдвэрлэсэн.</p> <p>Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ашиглаж буй хяналтын 49 камераас энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 22 хяналтын камер хэвийн ажиллаж, 27 хяналтын камер ажиллахгүй байгаа тул түүнийг засварлахад шаардлагатай техник хэрэгслийн төсөв тооцоог “Линк сервис” ХХК-иар гаргуулан, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 3.750.000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авах бэлтгэл ажлыг хангаад байна. Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Алтанбулаг сум дахь цагдаагийн хэлтсээс тус сумын төвд хяналтын камер тавиулах хүсэлтийг сумын Засаг даргад хүргүүлснээр энэ оны 1 дүгээр улиралд 5.000.000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, 6 ширхэг хяналтын камер суурилуулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.</p>

		<p>3.14. Төрийн бүх шатны байгууллага болон аж ахуйн нэгжид хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа зэрэг сэдвүүдээр мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулах.</p>	<p>Тайлангийн хугацаанд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа, хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих, эрт илрүүлэх чиглэлээр 14 удаагийн сургалтыг 3000 гаруй иргэдийн дунд зохион байгуулж, сургалтад оролцогчдод 8 төрлийн 2000 гаруй гарын авлага материалыг тараасан. “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай хамтран нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдад “Хүүхэдтэй харилцах арга зүй”, “Хүчирхийллийн хохирогч хүүхдийг таньж мэдэх аргачлал” сэдвийн хүрээнд чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, 250 алба хаагчийг хамруулсан.</p>
		<p>3.15. Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтарсан багийн бүрэлдэхүүнд ерөнхий боловсролын сургуулийн захирлыг нэмж оруулах.</p>	<p>Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу сум, хороонд Хүүхэд хамгааллын хамтарсан баг ажилладаг бөгөөд тухайн хамтарсан багийн бүрэлдэхүүнд сургуулийн нийгмийн ажилтныг ажиллуулж байна. 2018 онд батлагдсан “Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлого, 2019 онд батлагдсан “ЕБС-ийн орчны аюулгүй байдлын стандарт”-д сургуулийн орчинд хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг сургуулийн орчинд хамгаалах хариуцлага, чиг үүргийг дүрэм стандартаар ЕБС-ийн захирал хариуцан зохион байгуулахаар тусгасан.</p>
		<p>3.16. Хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байр, хорих ангид хууль тогтоомжид нийцүүлэн камерын хяналтын системийг бүрэн нэвтрүүлэх.</p>	<p>Нийслэлийн 162 их, дээд сургууль, 251 ЕБС-ийн гадна талд байрлуулсан 578, дотор талд байрлуулсан 1360, нийт 1938 хяналтын камерт үзлэг шалгалт хийж, 125 камерын чиглэлийг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй чиглэлд харуулан чиглэл өөрчлүүлж, 290 хяналтын камерыг стандартад нийцсэн камераар солих талаар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн 189 барилга байгууламжыг үзэж шалган, камержуулалтыг сайжруулах чиглэлээр “Шаардлага” өгч ажилласан. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага MNS 5633:2019 стандарт ЕБС-ийн дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандарт ЕБС-ийн орчны аюулгүй байдлын нийтлэг шаардлага MNS6782:2019 стандарт Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS:2019 стандарт Хүүхдийн тоглоомын талбайн орчинд тавих нийтлэг шаардлага MNS6751:2019 стандартуудыг баталсан. Эдгээр стандартуудын хэрэгжилтийн хүрээнд цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байр, хорих ангид хууль тогтоомжид нийцүүлэн камерын хяналтын системийг бүрэн нэвтрүүлсэн.</p>
		<p>3.17. Баар, зочид буудал, саун, цахим тоглоомын газар, интернэт төвүүдэд тавигдах стандарт, шаардлагыг шинэчлэх, хууль, хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагатай хамтран тэдгээрийн үйл</p>	<p>2019 онд хоолны газарт мөрдөх стандарт шинэчлэгдэн “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих, Шаардлага MNS 4946:2019” 2019 оны 07.31-н ий өдрийн Стандарт хэмжилзүйн газрын даргын С/34 тушаалаар батлагдсан. Стандарт 2019 онд бүрэн хэрэгжсэн. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар коронавирусын халдвараас шалтгаалан үйл ажиллагаа зогссон тул төлөвлөгөөт шалгалт бааранд хийгдээгүй. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх хяналтаар 2020 оны 1 дүгээр улиралд улсын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчилдэг давхардсан тоогоор баар 1799, ресторан 1503, кафе 348 шалгаж зөрчил арилгуулах арга</p>

		<p>ажиллагаанд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулах, хууль тогтоомж зөрчигчид хариуцлага хүлээлгэх ажлыг эрчимжүүлэх.</p>	<p>хэмжээ авлаа. Тухайлбал: нийслэлийн Сонгинохайран дүүргийн 19 дүгээр 1/58 дугаар байрны Овоо шил ХХК-ийн "Амуу" кафе, Чингэлтэй дүүргийн 8-р хороо, Гипт рояал ХХК-ийн ресторан, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Мика зочид буудлын 1 дүгээр давхарт Кенара ХХК-ийн "Алваро" ресторонууд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй, Баянгол дүүргийн 8 дугаар хороо, 9А байрны 1 тоотод байрлах байрлах Кайнд трейдинг ХХК-ийн Стрийт 88 ресторонуудын цаг хэтрүүлэн ажиллаж байсан, Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо, 40 мянгатын 28 байрны 03 тоотын Аянгын бороо ХХК-ийн One way ресторан, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 36 дугаар байрны 2 тоотын Гранд Будда ХХК-ийн Гранд Инн ресторан, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 22-аар байрны 13 тоотын Дэлгэрэнт трейд ХХК-ийн Аялгуу кафенууд нь цаг хэтрүүлэн ажиллаж байсан зөрчлийг илрүүлж, 11 аж ахуйн нэгжид 13500.0 мянган төгрөг, 2 иргэнд 770.0 мянган төгрөг, нийт 14270.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан, 77 заалт бүхий улсын байцаагчийн 6 албан шаардлага, 6 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг нийслэлийн Захирагчийн ажлын албанд, караоке үйлчилгээ явуулах 1 зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг нийслэлийн Соёл урлагийн газарт тус тус хүргүүлж, Архангай аймгийн "Хас", "Эрдэнэт" зоогийн газрын зөрчлийг газар дээр нь арилгуулан, нийслэлийн СХД-ийн 19 дүгээр 1/58 дугаар байрны Овоо шил ХХК-ийн "Амуу" кафе тогтоосон цаг хэтрүүлэн ажиллаж байсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу 150.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. Мөн нийслэлийн Баянгол дүүргийн "Жи ар ди реалти", "Ирмүүн энх", "Бат ангараг", "Эс өү эр ди ви" зэрэг ХХК-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын ажлын байр нь "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавигдах шаардлага" MNS 4946:2019 стандартын шаардлага хангахгүй, өөр хэлбэл хоол үйлдвэрлэл явуулдаггүй зөвхөн согтууруулах ундаагаар үйлчилж байсан зөрчлийг илрүүлэн албан шаардлага өгөв. 2020 онд нийслэлийн Захирагчийн ажлын албанаас үйлдвэрлэл үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах хяналт шалгалтад Мэргэжлийн хяналтын байгууллагыг оролцуулаагүй байна.</p>
		<p>3.18. Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>Коронавирусын тархалттай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосон байгаа тул хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр "Dream" телевизтэй хамтран "Сэргийлэгч хүү, Зөвлөгч охин" -ны санамж видео контент 2, "Сошиал медиа чаннел" студитэй хамтран цахим орчны нөлөө, цахим донтолтоос урьдчилан сэргийлэх цуврал санамж видео контент 2 дугаар, нөлөөллийн постер 3, "Ухаалаг утсанд донтохоос сэргийлье" сэдэвт шууд нэвтрүүлгийн 1 дугаар бэлтгэн цахим орчинд байршуулсан ба дээрх мэдээллийг 413.211 хүн үзэж, 5145 хүн бусадтай хуваалцсан байна.</p>

		<p>3.19. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжийг байгуулан ажиллуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх ажилд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг оролцуулах.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг байгуулсан. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүрт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч ажиллаж байна. Улсын хэмжээнд ажиллаж байгаа 676 хамтарсан багт цагдаагийн алба хаагч ажиллаж хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх зэрэг шийдвэр гаргахад хамтран ажиллаж байгаа болно.</p>
		<p>4. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тайлагнахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 382 дугаар тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны ажлын алба Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны бүтцэд ажиллаж байгаад 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны ажлын албыг Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах тухай Засгийн газрын тогтоол гарсан. Дээрх хугацаанд тус яам салбар дундын жендэрийн бодлого төлөвлөлт, зохицуулалтыг хариуцан гүйцэтгэж байсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйл “Жендэрийн үндэсний хорооны чиг үүрэг”-т хамрагдах асуудал болно.</p>
<p><b>Нийт 6 тогтоолын 36 заалт</b></p>			

Танилцуулга бэлтгэсэн ХШҮХ-ийн референт К.Пүрэвсүрэн